



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.09.25, МЯГМАР ~ №188 (987)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Дараалал харгалзахгүй хэлэлцэх асуудал олон байна

Хүүхэд хамгааллын тухай хуулийг шинэчлэх нийгмийн хүлээлт үүссэн. > 2

FT ШИЛДЭГ НИЙТЛЭЛҮҮД ТАНД ХҮРЧ БАЙНА > 9-10

FINANCIAL TIMES

Антибиотикоос татгалзснаар өвчлөл хүндэрч байна

Антибиотикийг чихэр шиг "идэж" болохгүй, хэрэглээнээс хасаж бүр ч болохгүй. > 4

FULL ENGLISH PAGE INSIDE > 7

ZGM DAILY

ОНЦЛОХ

УЛС ТӨР
Ерөнхийлөгч Х.Баттулга Бүгд Найрамдах Азербайжан улсад ажлын айлчлал хийж байна.
Сайд Д.Сумъяабазар ОХУ-д нефть ханган нийлүүлэлтийн талаар албаныхантай уулзаж байна.
ТАЗ: 132 хүн төрийн удирдах албан тушаалд үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байна.
Н.Энхбаяр нарын өргөн барьсан намын дүрмийн шинэчлэлийг УДШ бүртгэлээ.

ЭДИЙН ЗАСАГ
Азийн хөгжлийн банк эдийн засгийн ээлжит тоймоо маргааш танилцуулна.
Европын холбооны дэмжлэгтэйгээр 2.3 сая еврогийн төсөл нэхмэлийн салбарт хэрэгжиж эхэллээ.
"Ард даатгал"-ын анхдагч зах зээлийн үнэт цаасны захиалга лхагва гарagt хаагдана.
ТОП 20 индекс 19864.79 нэгж болж, 0.39 хувиар буурчээ.



НИЙГЭМ
Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолоочийг иргэдийн мэдээллийн дагуу торгоно.
Хотын дарга Чойжин ламын сүм музейн хашаан дахь барилгыг нураана гэв.
Хэрлэн, Онон голд живсэн байж болзошгүй иргэдийг ОБГ-аас эрэн хайж байна.
Үндэсний цэцэрлэгт хүрээлэн дэх 20 ТҮЦ-ийн гэрээг цуцална.

ДЭЛХИЙ
Бээжин: АНУ дэлхийн олон талт худалдааны харилцаанд заналхийлж байна.
ОПЕК олборлолтоо өсгөхгүй байхаар шийдмэгц газрын тосны үнэ өслөө.
Porsche компани бүтээгдэхүүндээ дизель хөдөлгүүрийн хэрэглэхгүй.
ОХУ-ын сөрөг хүчний удирдагч Навалнын хорионоос сулламагцаа дахин баривчлав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
 2018.09.25

19° | 5°

ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭГЭЭРНИЙГ МЭДЭЭЛЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Замын-Үүд үү, замын садаа юу



Замын-Үүд бол монголчуудын өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний 70-80 хувь нь орж ирдэг стратегийн чухал боомт. Гэвч өдөрт 6-8 мянган хүн нэвтэрдэг уг боомт интернетийн сүлжээ тасарсан гэх ялхгүй шалтгааны улмаас иргэдийг удаан хугацаагаар саатуулж, галт тэрэгнээс нь хоцроодог болсоор удаж байна. > 3

ЭДИЙН ЗАСАГ

Зээлийн хүү оны эхнээс 0.5-2.2 хувиар буурчээ

Г.Байгал
 @baigalZGM

Монгол Улс зээлийн хүүгээр дэлхийд харьцангуй өндөрт, харин хадгаламжийн хүүгээр маш өндөр ангилалд жагсдаг. Дэлхийн банк 2016 онд улс орнуудын зээл болон хадгаламжийн хүүг тав ангилан, авч үзэхэд Монгол Улс ийн бичигджээ. Ингэснээр бид зээлийн өртгөөр Төв Африк, бага болон Дундад Азийн орнуудтай зэрэгцэж байна. Гэхдээ зээлийн хүү нь 52 хувьд хүрсэн Бразил, 27 хувийн дундаж хүүтэй Аргентин зэрэг Латин Америкийн орнуудаас доогуур байгаа гэж төв банк мэдээллээ. Харин хадгаламжийн хүүгээр Латин Америк болон Төв Африкийн улсуудтай эн зэрэгцэж байна. Тэгвэл долдугаар сарын байдлаар иргэдэд олгосон төгрөгийн зээлийн дундаж хүү 18.1, бизнесийнх 17.4 хувьд хүрснийг төв банк мэдээлсэн юм. Иргэдэд олгосон зээлийн хүү оны эхнээс 2.2 хувиар буурсан бол бизнесийнх 0.5 хувиар багасчээ. Ингэснээр хэрэглээний зээл өмнөх оны мөн үеэс 24.8 хувиар өсөж, 7.6 их наяд төгрөгтэй тэнцсэн. Харин бизнесийн зээлийн өсөлт 15.7 хувь байгаа нь сүүлийн зургаан жилийн хамгийн өндөр үзүүлэлт гэж Монголбанк мэдээллээ.

ЗГМ: ИНФОГРАФИК

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД
 2018 оны VIII сарын эцэст

НИЙТ 23056

10865
 насны бүлгээг
 15-24: 2229 | 25-34: 3870 | 35-44: 2481 | 45-54: 1670 | 55-59: 484 | 60+: 131

12191
 насны бүлгээг
 15-24: 2520 | 25-34: 4642 | 35-44: 2921 | 45-54: 1750 | 55-59: 271 | 60+: 87

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд

55515
 шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд

12601
 бүртгэлтэй ажилгүй иргэдээс ажилд орсон

УСХ

ЗГМ: СУРВАЛЖИЛГА

Дундаж наслалт уртсахад тархины өвчин ихэсдэг

З.Цэлмэг
 @tselmegZGM

Тархины нууцыг тайлахын тулд амьдралынхаа 30 шахам жилийг зарцуулсан Норвегийн эрдэмтэн Эдуард Мозер монголчуудад зориулан Нобелийн шагнал хүртсэн нээлтээ илтгэлээ. Тэрбээр хүн орон зай, цаг хугацааны баримжааг тархиндаа хэрхэн хүлээн авч, боловсруулж, эргээд үйлдэл болгож гаргадаг талаар тун сонирхолтой мэдээлэл хуваалцсан юм. Эл судалгаагаараа 2014 онд Нобелийн шагнал хүртсэн тэрбээр хүний тархинд grid буюу маш олон давхарга бүхий эсүүд байдаг бөгөөд тэдгээр нь босоо, хөндлөн гээд гурван хэмжээст байрлалтай.

Тухайн хүний байршил өөрчлөгдөхөд grid эс рүү мэдээлэл дамжуулж, тэмдэглэн авч, эргээд хариу үйлдэл үзүүлдэг гэдгийг тэрбээр тогтоосон байна. Өөрөөр хэлбэл, тархи цаг хугацаа, орон зайг гурван хэмжээст механизмар бүртгэж авдаг байна. Угтаа бол хүн цаг хугацаа, орон зайг тархин дотроо хэрхэн зураглагдгийг эрдэмтэд 100-гаад жилийн өмнөөс хархан дээр анх туршиж байжээ. 1950-1960-аад оноос орон зайн байршил хүний тархинд хэрхэн кодлогддогийг Эдуард Толмон томъёолсон боловч учир шалтгааныг нь тайлбарлах шинжлэх ухааны аргачлал тухайн үедээ байгаагүй аж.

FT Хятадыг сөрөхийн тулд АНУ \$60 тэрбумыг зарцуулна

Дэвид Пиллинг

АНУ хөгжиж буй орнуудад 60 тэрбум ам.долларын хөрөнгө оруулах зорилго бүхий агентлаг байгуулахаар төлөвлөж байна. Үүнийг Вашингтоны зарим албаныхан тайлбарлахдаа эдийн засгийн дайнд ялахын тулд хятадын өр зээл ашиглаж буй бодлогыг сөрөх стратеги хэмээжээ. Ажиллагчид энэ алхмыг сүүлийн 50 жилд хөгжиж буй орнуудад арилжааны зээл олгоход хийгдэх хамгийн том шинэчлэл гэж үнэлэв. Гадаадын хувийн хөрөнгө оруулалтын корпорацыг (ОПIC) шинэ агентлаг болгон зохион байгуулж, хувьцаанд хөрөнгө оруулах аж. Өнөөгийн байдлаар ОПIC зөвхөн өрийн бичиг худалдан авч байгаа нь Европын хөгжлийн санхүүжилтийн байгууллагуудтай харьцуулахад давуу талаа алдаж байна гэж үзсэн юм. ОПIC-ын ерөнхий захирал Рей Вайшборн Financial Times сонинд ярихдаа, хятадууд зээлийг эзэмшил болгох хөтөлбөр хэрэгжүүлж, өрийн гинжинд оосорлуулсан улс орнуудыг бий болгож байгаа нь эдийн засгийн дайны хэлбэр хэмээн онцлов.

АЛТ 1198.70 0.11%	ЗЭС 6363 4.62%	10-ЧИНГИС БОНД 94.50 0.14%	ХУРАЛДАЙ БОНД 108.32 0.13%	ГЭРЭГЭ БОНД 95.210 0.15%	АМ.ДОЛЛАР 2523.10	ЮАНЬ 367.95	РУБЛЬ 38.13
--------------------------------	-----------------------------	---	---	---------------------------------------	-----------------------------	-----------------------	-----------------------

Улс төр

ПАРЛАМЕНТ

Дараалал харгалзахгүй хэлэлцэх асуудал олон байна



С.Батсайхан / ЗГМФ

Хүүхэд хамгааллын тухай хуулийг шинэчлэх нийгмийн хүлээлт үүссэн

П.Батбөх
ЗГМ

Намрын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг УИХ-ын даргын захирамжаар баталжээ. Жагсаалтын эхэнд Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэхээр төвлөсөн байна. Ээлжит намрын чуулган бүрийн эхэнд энэ асуудал байдаг нь уламжлал. Хуулиар арванхоёрдугаар сарын нэгнээс өмнө төсвөө батлах үүрэг парламентад ногддог. Гэвч төсвийн хуулийг хэлэлцэх завдалгүй шилээ дарсан улс төрийн халуухан үйл явдлууд өрнөх нь.

Чуулганы нээлтийн дараа дараалал харгалзахгүй хэлэлцэх хэд хэдэн асуудал бий.

Юун түүрүүнд төрийн дутуу бодлого, томчуудын хайхрамжгүй, хариуцлагагүй байдал... гээд олон хүчин зүйлээс бол хаягдаж буй хүүхдийн эрхийн асуудлыг хөндөхгүй орхиж болохгүй. Энэ оны эхний хагас жилийн байдлаар 150 гаруй хүүхэд ямар нэгэн золгүй тохиолдол, гэмт хэргийн золиос болж хорвоогоос одсон гээд бодохоор Монголын нийгмийн онгорхой цоорхой бүрээр унан гээгдэж буй нь хүүхдүүд юм байна гэдгийг

баталж байгаа юм. Тиймээс улс төрийн нөхцөл байдал, сайд дарга нарын томилгоо, төсөв мөнгөний бодлогоос түрүүлж хүүхэд хамгааллын хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, Хүүхэд хамгааллын тухай хуулийг шинэчлэх зайлшгүй шаардлага үүссэн. Хаврын чуулганы завсарлагааны хугацаанд зарим гишүүн энэ асуудлыг хөндөн, хүүхэд хамгааллын талаар шийдвэртэй арга хэмжээ авах цаг болсныг мэдээлж байсан. Тиймээс намрын чуулганы хэлэлцэх асуудлын дарааллын эхний эгнийнд Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл байх болов уу гэсэн нийгмийн хүлээлт байна. УИХ-ын сонгуулийн 42-р тойрогт нөхөн сонгууль явуулахаар төвлөсөн УИХ-ын тогтоолыг Үндсэн хуулийн цэц түдгэлзүүлснийг ярина. Цэцийн дүгнэлтийг ээлжит чуулган эхэлснээс хойш тав хоногийн дотор холбогдох Байнгын хороо болон УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэн, хүлээж авах эсэхээ шийдэх хуультай. УИХ-ын чуулганаар Цэцийн шийдвэрийг хүлээн авах боломжгүй гэвэл ҮХЦ Их суудлын хуралдаанаараа УИХ-ын шийдвэрийг хэлэлцэн эцэслэх юм. Үүнтэй зэрэгцэн УИХ-ын 22 гишүүн хүсэлт гарган ээлжит бус чуулган зарлан хуралдуулж 60 тэрбумын асуудлаар нээлттэй сонсгол хийх шаардлага тавиад байсан ч эрх зүйн үндэслэлгүй болсон. УИХ-ын зүгээс нээлттэй сонсгол зохион байгуулахаар УЕПГ-т хандсан ч Ерөнхий прокурор М.Энх-

Амгалан “Тухайлсан хэргээр нээлттэй сонсгол, хэлэлцүүлэг хийх эрх зүйн боломжгүй” гэсэн тайлбарыг хийснээр энэ асуудал замхарсан юм.

Харин Ерөнхийлөгч Х.Баттулга болон УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын хүсэлтийн дагуу АТГ-ын дарга Х.Энхжаргалыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх эсэхийг намрын чуулганы эхэнд хэлэлцэх ёстой. Өнгөрсөн зун АТГ-ын даргатай холбоотой асуудлыг Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцүүлэх, улмаар ээлжит бус чуулган зарлан хуралдуулах нөхцөл бүрдсэн боловч тус байнгын хорооны гишүүдийн ирц бүрдэхгүй байсаар ээлжит чуулгантай золгосон. Энэ удаа гишүүдийн ирц хүрэхгүйн зовлонгүй учраас хойшлуулж “шогтохгүй” нь ойлгомжтой. Үүнд дөрөөлөн УИХ-ын даргыг огцруулах улс төрийн акц ч өрнөхийг үгүйсгэхгүй. Мөн ЗТХ-ийн сайдын томилгоо УИХ-ын чуулганыг хүлээж буй.

Энэ мэт УИХ-ын намрын чуулганы жагсаалтад ороогүй хэргэг явдлууд өрнөх бол жагсаалтаар хэлэлцэх асуудлууд ч ширүүн маргаан үүсгэх биз. Ялангуяа улстөрчид, судлаачдын дунд хамгийн их маргаан дагуулж байгаа Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл хаврын чуулганаас улиран орж ирлээ. Эцэг хуулийн шинэчлэлийн асуудал бараг сүүлийн гурван парламентын хугацаанд ээлжит чуулганы эхэнд хэлэлцэх асуудлын дараалалд байсаар ирсэн тул энэ нь шинэ сэдэв биш. УИХ-ын 2016 оны 45 дугаар

тогтоолоор баталсан “2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-т “...эрх мэдлийн харилцан хяналттай, тогтвортой, хариуцлагатай төрийг бий болгохын төлөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан ард түмнээсээ асууж шийдвэрлэнэ.” хэмээн тусгасан. Уг тогтоолын дагуу ард нийтийн санал асуулга ч явуулах нөхцөл байдал бүрдэх магадтай. Мөн Ерөнхийлөгчийн сонгууль, УИХ-ын сонгууль, Аймаг сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулиуд ч улс төрийн намуудад хамаатай

учраас хэлэлцүүлгээс эхлээд хэрүүл, маргаан дагуулж мэднэ. Үүн дээр Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Төрийн байгуулалтын байнгын хороог завгүй ажиллуулах нь.

Улсын төсөв хэлэлцэхтэй зэрэгцэн Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороогоор Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн төсөл, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн төсөл, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэлийг батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэх юм. Үүнээс гадна хаврын чуулганаар баталж амжаагүй Аж аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Харин хаврын чуулганы хугацаанд болон өнгөрсөн зун хууль санаачлагчаас өргөн барьсан шинэчлэн найруулах болон нэмэлт өөрчлөлт оруулах 11 хуулийн төслийг хэлэлцэхээр болжээ.

Дээрхээс дүгнэхэд сэрүүн намраар улс төрийн халуухан сэдвүүд Төрийн ордонд яригдах болж байна. Гэхдээ УИХ-ын даргын зөвлөл энэ долоо хоногт дахин хуралдаж намрын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг авч хэлэлцэхээр болсныг эх сурвалж хэллээ. [ЗГМ]

● **УИХ-аар юун түүрүүнд УИХ-ын сонгуулийн 42-р тойрогт нөхөн сонгууль явуулахаар төвлөсөн УИХ-ын тогтоолыг Үндсэн хуулийн цэц түдгэлзүүлснийг ярилцана.**

● **Ерөнхийлөгч болон УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нарын хүсэлтийн дагуу АТГ-ын дарга Х.Энхжаргалыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх эсэхийг намрын чуулганы эхэнд бас хэлэлцэх ёстой.**

● **Улстөрч, судлаачдын дунд хамгийн их маргаан дагуулж байгаа Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл хаврын чуулганаас улиран орж ирлээ.**

ЗГМ ТОВЧХОН

» АЙЛЧЛАЛ

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Бүгд Найрамдах Азербайжан улсад ажлын айлчлал хийхээр очигдох тус улсын нийслэл Баку хотноо очлоо.

Тэрбээр ажлын айлчлал хийх үеэрээ Бүгд Найрамдах Азербайжан улсын Ерөнхийлөгч Илхам Алиевтай уулзана. Мөн Азербайжан улсын баялгийн сан буюу газрын тосны сангийн удирдлагуудтай уулзаж үйл ажиллагаатай нь танилцана.

» ЯАМ

УУХУ-ийн сайд Д.Сумъяабазар ОХУ-д айлчлал хийнэ. Тус айлчлалаар Владивосток хотод болсон Дорнын эдийн засгийн IV уулзалтын үеэр хоёр орны хооронд ярилцсан зарим саналуудыг нарийвчлан судлах, бодит ажил хэрэг болгоход чиглэсэн ажлуудыг төлөвлөх, газрын тосны бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн талаар ОХУ-ын холбогдох албаныхантай хэлэлцээ хийх юм.

» НАМ

МАХН-ын шинэчлэн найруулсан дүрэм, мөрийн хөтөлбөрийг бүртгүүлэх тухай тус намаас гаргасан хүсэлтийг Дээд шүүх хэлэлцэн бүртгэж авах шийдвэр гаргажээ. Тус намаас өмнө нь дүрмийн өөрчлөлт, тамга тэмдгээ бүртгүүлэхээр хандаад байсан боловч намын дүрмээ Их чуулганаараа хэлэлцүүлээгүй гэх шалтгаанаар хүлээн авахаас татгалзаад байсан юм.

» ШАЛГАЛТ

ТАЗ-өөс УИХ, Засгийн газар, яам, агентлаг, төрийн байгууллагуудад шалгалт хийхэд Төрийн албаны зөвлөлийн сонгон шалгаруулалт дүгнэлтгүйгээр 132 хүнийг төрийн албаны удирдах албан тушаалд түр үүрэг гүйцэтгэгчээр ажиллуулж байгаа зөрчил илэрчээ. Дээрх зөрчлийг арилгах үүднээс ТАЗ шалгалт авч тэнцээгүй албан тушаалтнуудыг чөлөөлөхөөр болжээ.

» ТОО

2.5

Их наяд төгрөг. Сангийн яамнаас 2018 онд нийгмийн хамгааллын үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийн хэмжээг 2.5 их наяд төгрөг хэмээн зарлав. Энэ нь Монгол Улсын төсвийн зарлагын 26 хувьтай тэнцэж байгаа бөгөөд өмнөх оныхоос 292.2 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

АЙЛЧЛАЛ

Ерөнхий сайд ОУВС-гийн тэргүүнтэй уулзжээ

АНУ-д айлчилж буй Ерөнхий сайд У.Хүрэлсүх өнгөрсөн долоо хоногт Олон улсын валютын сан (ОУВС)-гийн тэргүүн хатагтай К.Лагардтай уулзаж, тус сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн үр дүнд, цаашид авах арга хэмжээний талаар дэлгэрэнгүй ярилцжээ.

Хөтөлбөрийн үр дүнд Монголын эдийн засгийн өсөлт 2016 онд 1.2 хувь байсан бол 2018 оны эхний хагас жилийн байдлаар 6.3 хувь, цаашлаад 2019 онд найм орчим хувиар өсөх төлөвтэй байна. Түүнчлэн төсвийн нэгдмэл байдал, сахилга батыг сайжруулснаар байнгын алдагдалтай явж ирсэн төсвийн үзүүлэлт эрс сайжирч, төсвийн үндсэн тэнцэл 2018 онд анх удаа ашигтай гарч, улмаар 2019 онд дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувьтай тэнцэх ашигтай гарахаар тооцож байгаа юм.

ОУВС-гийн тэргүүн К.Лагард инфляц зорилтот түвшинд хадгалагдан, гадаад валютын нөөц чамлалтгүйгээр өсч,



банкны салбарыг эрүүлжүүлэх, хууль эрх зүйн орчинг сайжруулах зэрэг ажлууд хийгдэн эхний үр дүнгээ өгч эхэлснийг онцлон тэмдэглэв. Тэрбээр “Монгол Улс гадаад болон дотоод шокуудад мэдрэг байгаа тул хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, төсвийн алдагдлыг бууруулах, гадаад валютын нөөцийг эрүүлжүүлэн нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байгааг

анхаарах хэрэгтэй. Үүсч болзошгүй шокын эсрэг арга хэмжээг боловсруулах нь зүйтэй” хэмээв. Ерөнхий сайд “Цаашид Монгол Улсын Засгийн газар, ОУВС-тай хамтран хэрэгжүүлж байгаа “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг улам үр дүнтэй хэрэгжүүлж эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах, хүртээмжийг улам бүр нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана” гэжээ. [ЗГМ]

ЦАХИМ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Огноо: 2018.09.25

Тендер шалгаруулалтын нэр: **Агаарын хөлгийн шатахуун нийлүүлэх компани сонгон шалгаруулах тендер**

Тендер шалгаруулалтын дугаар: **МИАТ/201801001**

МИАТ ТӨХК нь эрх бүхий тендер оролцогчдоос **“Агаарын хөлгийн шатахуун нийлүүлэх”** тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер оролцогчид эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50000 төгрөг, төлөн www.tender.gov.mn цахим сайтад тоон гарын үсгээрээ нэвтрэн орж оролцож болно. Тендер нь түүнийг нэсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Багц №1 Агаарын хөлгийн 13,500 тонн шатахуун Улсын хил нөхцөлөөр нийлүүлэх, Тендерийн хамт 541,698,300/таван зуун дөчин нэгэн сая зургаан зуун ерэн найман мянга гурван зуу/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Багц №2 Агаарын хөлгийн 13,500 тонн шатахууныг Дамжуулан хадгалах, агуулахын үйлчилгээ үзүүлэх, Тендерийн хамт 10,000,000/арван сая/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Багц №3 Агаарын хөлгийн 13,500 тонн шатахууныг тээвэрлэх, хадгалах, агаарын хөлгийг сумлах үйлчилгээ үзүүлэх, Тендерийн хамт 32,120,000/Гучин хоёр сая нэг зуун хорин мянга/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2018 оны 10-р сарын 25 -ний өдрийн 11.00 цагаас өмнө цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 10-р сарын 25 –ны өдрийн 11.30 цагт нээнэ.

Гадаадын хуулийн этгээд тендер оролцох эрхтэй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

ХАЯГ: Хан-Уул дүүрэг 10-р хороо “МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУЬЦААТ КОМПАНИ Харилцах утас 91914093, Факс 976-11-7004-9919

Нийтлэлчийн булан

Сүлжээ тасарснаас болж ганц өдөрт 100 шахам хүн галт тэрэгнээс хоцордог

Г.Баярсайхан
@bayarsaikhanZGM

Дорноговь аймгийн Замын-Үүд боомт өмнөд хөрштэй хийх худалдаа наймааны гол зангилаа бүс. Цаг үе чөлөөтэй болж, зах зээлд шилжсэн 1990-ээд оноос хойш уг боомтоор монголчууд цувж, ачаа бараа зөөж эхэлснээс хойш 30 шахам жил өнгөрчээ. Монголчуудын өргөн хэрэглээний барааны 70-80 хувь зөвхөн Замын-Үүдээр дамжин ирдэг гэж бодохоор ачаалал, хөл хөдөлгөөн ямар байх нь ойлгогдох байх. Энэ боомтоор өдөр 6-8 мянган хүн, 800-1000 машин хил нэвтэрч, бидний өдөр тутамдаа хэрэглэдэг хувцас хунараас авахуулаад барилгын материал, цахилгаан бараа, хоол хүнс гээд есөн шидийн юм зөөсөөр байна. Өнгөрсөн жил Замын-Үүдээр 1.1 сая тонн ачаа төмөр замаар гарсан нь түүхэнд байгаагүй амжилт болсон гээд тус боомтын ач холбогдлыг тодотгох баримт олон.

Өнгөрсөн жилүүдэд Замын-Үүд сум болон Эрэн хотын хөгжлийн ялгаа ямар түвшинд хүрсэн талаар бид олонтаа ярьсан. Тиймээс энэ сэдвийг түр орхиё. Харин хоёр боомтоор нэвтрэх хурд, үйлчилгээний чанар зайлшгүй яригдах ёстой



Б.Батдорж / ЗГМӨ

Эрээний боомтын цэлийсэн заалнаас гараад Монголын хилээр орж ирэхэд оготны нүх шиг санагддаг. Яарч адгасан хүмүүс энэхүү жижиг зааланд “алаан” болж байтал дайран дээр давс гэгчээр сүлжээ нь байсхийгээд тасалдаж, олныг зутраасаар байна.

болж, жирийн иргэдийн мөнгө хий дэмий урсаар байгаа юм.

Уг нь Замын-Үүд бол Монгол орны бусад 330 гаруй сумтай харьцуулахад онцгой бүс нутаг. Бидний өргөн хэрэглэдэг ихэнх бараа энэ боомтоор орж ирдэг болохоор анхаарлаа сайн хандуулдаг, түргэн үйлчилдэг, бэрхшээл гарахад шуурхай шийддэг байх ёстой. Эрэн хот шиг өндөр хөгжилтэй болгооход гэж шаардахаа больё. Ядаж интернет сүлжээгээ асуудалгүй болгочихвол бага ч гэсэн дэвшил авчрач гээд байна.

Энэ талаар Замын-Үүд сумын Засаг дарга Н.Алдарбаяртай холбогдож тодруулахад “Хил хяналтын байгууллага босоо удирдлагатай байдаг. Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Замын-Үүдийн шалган нэвтрүүлэх 0108 дугаар анги яг энэ сүлжээний асуудлыг хариуцаж байгаа. Шилэн кабелийнхаа хүчин чадлаас болоод сүлжээ доголдох, саатах асуудал гардаг. Үүнийг хүлээн зөвшөөрнө. Орон нутгийн зүгээс энэ асуудлыг шийдэхэд эрх мэдэл хүрдэггүй болохоор яах ч аргагүй байна” хэмээн тайлбарлалаа.

Харин асуудлыг гардан хариуцаж буй 0108 дугаар ангийн дарга, хурандаа А.Энхтөртэй холбогдоход “Наад гомдол гаргасан хүнээ Замын-Үүдэд дагуулж ирээд ямар учир шалтгаантай асууж тодруулаарай” гэсэн үл бүтэх хариу өгөөд утсаа таслав.

Уг нь тэднийг газар дээр нь тулгарсан асуудлыг шийд гэж энэ албан тушаалд томилсон баймаар. Гэвч иргэдэд асар их түвэг чирэгдэл учруулчихаад санаа зовсон шинжгүй утсаар даналзаж байгаа нь дэндүү харамсалтай.

Өнгөрсөн зун Ерөнхий сайд У.Хүрэлсүх Замын-Үүдэд очиход дарга нар нь орон нутагт хийгдэж буй бүтээн байгуулалтаа ам уралдан магтаж, чухам л жаргалын диваажин болсон мэт мэдээлэл өгч байв. Бүс нутгийн ложистикийн төвийн бүтээн байгуулалт 85 хувьтай байгаа л гэнэ. 15 МВт-ын нарны цахилгаан станц ашиглалтад орлоо л гэнэ. Харин Ерөнхий сайдыг ирэхэд том том бүтээн бай-

гуулалт ярьж угтдаг хурган дарга нарын ажил бодит байдал дээр ямар байгааг хүн бүр хэлж байна.

“БНХАУ-ын Эрээний боомтоос Монгол Улсын Замын-Үүдийн боомт руу нэвтрэхэд жижигхэн лонх руу орж ирж байгаа юм шиг санагддаг. 1990-ээд оны үйлчилгээ, нөхцөл байдал яг хэвээр байна. Хоёр автобус буюу 90 орчим хүн орж ирэхэд л жижиг заал нь дүүрчихдэг. Гэтэл зорчигчдын урсгал нэмэгдсээр. Тийм учраас Замын-Үүд боомтын хүчин чадлыг сайжруулах талаар онцгой анхаарах ёстой” хэмээн тус сумын Засаг дарга Н.Алдарбаяр нэгэн ярилцлагадаа өгүүлж байв.

● **Монголчуудын өргөн хэрэглээний барааны 70-80 хувь зөвхөн Замын-Үүдээр орж ирдэг.**

● **“Замын-Үүдэд сүлжээ байнга л тасардаг. Үүнээс болж хүмүүс вагоноос хоцрох нь энгийн үзэгдэл болсон” гэв.**

● **Хоцорсон хүмүүс 15-20 мянган төгрөгөөр такси хөлслөн Сайншанд хүртэл давхиж, галт тэргээ гүйцдэг.**

Үнэхээр түүний хэлсэнчлэн Эрээний боомтын цэлийсэн заалнаас гараад Монголын хилээр орж ирэхэд оготны нүх шиг санагддаг нь нууц биш. Яарч адгасан хүмүүс энэхүү жижиг зааланд “алаан” болж, нэгнийхээ урд орчих гээд үзэж тарна. Гэтэл дайран дээр давс гэгчээр сүлжээ нь байсхийгээд тасалдаж, олныг зутраасаар байна. Сүлжээний доголдол гэх өчүүхэн асуудлаа шийдэж чадалгүй өнөөг хүрч байгаа нөхөд монголчуудыг хэдэн онд аялуулаад байна вэ. Чалдаггүй нэгний ажлыг чаддагт нь шилжүүлэх цаг болсон бус уу. [ЗГМ]

Замын-Үүд үү, замын садаа юу

сэдэв болоод улдаа. Манай хил, гаалийнхны хүнд суртал, техник тоног төхөөрөмжийн доголдлын талаар наймаа эрхлэгчид байнга гомдоллодог ч олигтой ахиц дэвшил гарсан зүйл огт алга.

Наймаачдын хувьд өглөөний 07 цагт Замын-Үүдэд буусан даруйд хамаг хурдаараа хил давж, бараагаа цуглуулах гэж яардаг. Өдөртөө багтаад буцан хилээр гарч, орой 18 цагт хөдлөх галт тэргэнд амжиж суухын тулд яарахаас ч аргагүй. Ингээд Эрээний захаар өдөржин хэсэж, хэдэн цаасандаа хэрэгтэй бараагаа цуглуулсны дараа Монголын хилээр нэвтрэх гэж үйлээ үзнэ дээ. Учир нь эндхийн дотоод сүлжээ ямар ч үед тасрах эрсдэлтэй тул гэнэтийн сюрпризд бэлэн байх ёстой. Хамгийн сүүлд л гэхэд энэ сарын 12-ны өдөр интернет сүлжээ нь бараг хоёр цаг тасалдсаны улмаас олон хүн галт тэргэнээсээ хоцроход хүрэв.

“Өдрийн 16.00 цагт сүлжээ тасраад 17.40-д ирсэн. Бид урдуур

зогсож байсан тулдаа вагондоо ам мөлтөс амжиж суусан юм. Бидний ард хорь, гучин машин үлдсэн гээд бодохоор 100 шахам хүн тэр өдөр вагондоо сууж чадалгүй хоцорсон” хэмээн Нарантуул захад бэлэн хувцас зардаг Мөнх хэмээх бүсгүй яриу. Харин Бөмбөгөр захад хувцасны лангуу түрээсэлдэг 32 настай Б “Замын-Үүдэд сүлжээ байнга тасардаг. Үүнээс болж хүмүүс вагоноос хоцрох нь энгийн үзэгдэл болсон. Би хүртэл нэг удаа хоцорч байлаа. Бараг долоо хоног бүр сүлжээ нь тасардаг юм билээ. Заримдаа хурдан янзалчихна. Харин заримдаа хоёр цаг ч хүлээх тохиолдол бий. Үнэхээр хэцүү. Биднийг хилээр гарах болгонд орон нутгийг хөгжүүлэх санд орно гээд мянган төгрөг хураадаг. Ядаж тэр мөнгөөрөө сүлжээг янзалж, чирэгдэлгүй үйлчилж болдоггүй юм байх даа” хэмээн бухимдангүй өгүүлэв.


Хил дээр саатаж, галт тэргэнээсээ хоцорсон хүмүүсийн хувьд

тэндээ хоноглох, эсвэл 15-20 мянган төгрөгөөр такси хөлслөн Сайншанд хүртэл давхиж, галт тэргээ гүйцэх гэсэн хоёр сонголттой тулгардаг байна. Хэрэв сумын төвд үлдэхээр бол зочид буудлын хөлс, хоолны зардлаас гадна хамгийн гол нь бүхэл бүтэн нэг хоног алдана. Иймд хүмүүс ихэвчлэн хоёр дахь замыг сонгодог аж. Сайншанд хүртэл шунгинах таксинууд хэдийнэ байраа эзлээд тэднийг хүлээж байдаг гэнэ. Өдөр болгон л хүмүүс хилийн арчаагүй байдлаас болж хэдэн арваараа галт тэргэнээс хоцордог болохоор үйлчлүүлэгч ихтэй байдаг аж.

Нэг хүн хамгийн багадаа 15 мянган нэмэлт зардал ийнхүү гаргаж байна. Тэгээд ганц өдөрт 100 шахам хүн хоцорч байна гэжээр сүлжээний доголдлоос болж ямар их үрүгүй зардал урсаж буй нь харагдах байх. Энэ байдал долоо хоногт 1-2 удаа давтагддаг хэмээн наймаачид гомдоллож буй. Тэгэхээр жижиг мэт асуудлын цаана том дарамт бий

УХААРАЛ ХАЙРЛАХ УРАН ШОГ

Мөргөлдөөн



Херлуф Бидструп



МЭДЭГДЭЛ

Хууль зүй, Дотоод хэргийн сайд Ц.Нямдоржийн гүтгэлэгт няцаалт өгөх тухай

Монголын Ардчилсан Холбоо 1989 оны 12 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан анхны цуглаанаас гаргасан өргөх бичигтээ “...Намаас төр, засгийн үйл ажиллагааг шууд удирдан чиглүүлэх замаар нөлөө үзүүлэх явдлыг зогсоох...”, эрх зүйт төр байгуулахыг шаардсан билээ.

Түүнээс хойш 29 жил өнгөрч, 1000 орчим хууль батлагдсан ч олон жил эрх барьсан МАХН (МАН) жинхэнэ эрх зүйт төр, хуулийн засаглал байгуулах явцыг санаатайгаар гуйвуулж, саармагжуулж ирсэн бөгөөд улмаар Монголын төрийг албан тушаал наймаалцагч, танил талын (клиенталист) засаглалын тогтолцоонд гүнзгий хутгалдууллаа. Энэ бол үндэсний аюулгүй байдлыг ноцтойгоор сулруулсан, эвлэрч болшгүй сөрөг үзэгдэл мөн.

Төрийн албыг нүсэржүүлж, хүнд сурталжуулах, найз нөхөд, дагагсад, садан төрлийн холбоот бүлэглэл болгон хувиргах, албан тушаалыг арилжаалах эхлэл МАН-ын дарга асан Н.Энхбаярын засаглалын жилүүдэд 2000 онд анхлан тавигдсан байдаг. Тэрбээр Ерөнхий сайдаар ажиллаж байхдаа УИХ-ын гишүүдэд тойрогтоо ажиллахад нь зориулж 10 сая төгрөг өгөх хуулийн төсөл санаачилж батлуулсан. “Тойргийн мөнгө” нь цаашдаа 2005 онд 100 сая, 2007 онд 250 сая, 2008 онд 500 сая, 2010 онд 1 тэрбум төгрөгт хүрч өсөж байлаа. Хуулийн засаглалыг уландаа гишгэсэн, албан тушаалыг мөнгөжүүлэх гэсэн энэ үзэгдэл цаашид ямар ноцтой түвшинд хүрч хөгжин цэцэглэснийг 2016 оны сонгуулиар шүгэл үлээгч Г.Доржзодовын илчилсэн “60 тэрбумын хэрэг” нийгэмд тод томруунаар харуулсан билээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржийн зүгээс Монголын Ардчилсан Холбоонд хаягласан гүтгэлэгт ч 60 тэрбумын хэргийг хацайлах, барьцах сэдэл ажиглагдаж байгаа нь харамсалтай. Тэрбээр 2018 оны 9 дүгээр сарын 19-нд 25-р суваг ТВ-ийн “25 цаг” нэвтрүүлэгт өгсөн тодруулга ярилцлагадаа “...Зам тээврийн яаман дээр хүний аминд халдсан хүнийг улс төрийнх нь угшлаар хөөх юм бол Ардчилсан нам, МоАХ фракцийн хүн байна лээ шд” хэмээн Зам, тээврийн яамны газрын дарга асан Б.Махбалыг МоАХ-ны гишүүн байсан, тэндээс төрийн албанд томилогдсон гэх утга бүхий мэдэгдэл хийлээ.

Бодит үнэнийг дуулгахад: Иргэн Б.Махбал нь МоАХ-ны гишүүнчлэлд огт хамрагдаагүй, манай аль ч үеийн бүртгэлд байхгүй хүн байна.

Лавлагаас, МоАХ-ны дарга Х.Баттулгыг 2008 онд Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдаар томилогдохоос өмнө төрийн албанд орсон, 2007 оноос Зам тээвэр, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнийн удирдлагын багт хамаарч байгаад Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам болон өөрчлөгдөхөд түүнийг дагаж ирсэн албан тушаалтан болох нь лавлах баримтуудаар нотлогдсон тул сайд Ц.Нямдоржийн баримтгүй гүтгэлгийг МоАХ энэ мэдэгдлээрээ албан ёсоор няцааж байна.

Хуулийн засаглалыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй яамыг толгойлж буй сайд Ц.Нямдоржийн зүгээс шүүх, хуулийн засаглалын тулгуур зарчмуудыг ноцтойгоор үгүйсгэх, үе үе МоАХ-г худал мэдээлэл, гүжир гүтгэлэгтээ хавчуулж гутаахыг оролдож ирснийг сануулж, баримт нотолгоогүйгээр гүтгэн харлуулах ажиллагаагаа зогсоож, хэвлэлээр дамжуулан уучлал гуйхыг хатуу шаардаж байна.

МоАХ анх байгуулагдсан цагаасаа зорьж ирсэн төрийн албыг эрүүлжүүлэх, иргэний оролцоо, хяналтыг сайжруулах, хуулийн засаглалыг төгөлдөржүүлэх, албан тушаалын наймаа, танил талын сүлжээг үндсээр нь устгах зорилгоо биелүүлэх чиглэлээр бодитой үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн, тууштай тэмцэхээ мэдэгдэж байна.

ЗГМ: Сурвалжилга

Нобелийн шагналын нээлт Алцгеймерийг эрт шатанд илрүүлэхэд тусална

Удалгүй тунгстен хэмээх элементийн тусламжтай мэдрэлийн нэг жижиг эсийг ч бүртгэх боломжтой жижиг электрод бий болсноор тархины бүх мэдээллийг бүртгэх боломж бий болсон гэдэг. Нобелийн шагналт Эдуард Мозер эрдэмтний эл нээлт орон зай, цаг хугацаагаар алдах, зүг чиг олох механизмаар алдах зэрэг шинж гэмдгээр илэрдэг Алцгеймер зэрэг тархины өвчнүүдийг эрт шатанд оношлох, эм болон эмчилгээний үр дүнтэй аргачлал боловсруулахад чухал ач холбогдолтой хэмээн үзэж буй аж. Энэ талаар ШУА-ийн ерөнхийлөгч Д.Рэгдэл “Хүн бүрийн мэдлэг Алцгеймерийн (монголчууд тархи цайрах гэдэг) буюу ой санамж арилах өвчин нь тархины аль аль эс үхсэнээс болж үүсдэгийг үндсэндээ тайлсан байна” хэмээв.

Харин мэдрэлийн эсэд нэвтрэх боломжтой электродын тусламжтай хүнийхээ бусад амьтны тархинд хүссэн мэдээллээ оруулж,



С.Батсайхан / ЗГМ

2010 оны байдлаар тархины өвчний эмчилгээний зардал 800 тэрбум евро хүрсэн нь хорт хавдар, чихрийн шижин, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчнөөс давсан үзүүлэлт аж.

тоо жилд 1.5 саяд хүрнэ гэсэн статистик байгааг эрдэмтэд сонирхуулаа. Тиймээс ч тархи судлалд өндөр хөгжилтэй орнууд асар их мөнгө хаяж буй бөгөөд дэлхий даяар судалгаа шинжилгээ идэвхжсэнээр сүүлийн 30 жилд тархи судлалын шинжлэх ухааны өгүүллийн тоо 7.8 дахин нэмэгдэж 758 мянгад хүрснийг эрдэмтэд онцолж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Монголын тархи судлалын нийгэмлэгээс зохион байгуулсан тус чуулганд Япон, Испани, БНСУ, Тайвань, Малайз, ОХУ, БНХАУ-ын болон үндэсний эрдэмтэн мэргэд, мэргэжилтнүүд оролцсон юм. Тархи, хүний дотор эрхтнүүд нарийн нягт холбоосоор холбогддог бөгөөд тархинд ирж буй аливаа стресс, сэтгэл гутрал дотор эрхтний өвчлөлд нөлөөлдөг. Тиймээс стрессийн шалтгаантай өвчлөлд эм, клиник эмчилгээнээс илүү сэтгэл засал, зан авир засах эмчилгээ үр дүнтэйг Японы Кюүшүгийн их сургуулийн эрдэмтэн, Фукуока хотын үндэсний эмнэлгийн психосоматикийн анагаах ухааны тасгийн эрхлэгч Тэцүяа Хирамото онцолсон юм.

Монгол Улсад тархи судлал ямар түвшинд байгаа, аль чиглэлд тулхуу хөгжүүлэх шаардлагатай талаар салбарын мэргэжилтэн, бодлого боловсруулагчид дараах тайлбарыг хэлж байна. [ЗГМ]

Дундаж наслалт уртсахад тархины өвчин ихэсдэг

зан төрхийг нь өөрчлөх боломжтой. Үүнийг оптогенетикийн шинжлэх ухаанаар тайлбарладаг аж. Тухайлбал, тархины хайр энэрийн төвийг уур бухимдлын төв болгох зэргээр тухайн амьтны зан байдлыг өөрчилж болно. Энэ туршилтыг харх, мөн 1960-аад оны үед буханд туршиж байсан гэдгийг Нейросайнс сэтгүүлийн ерөнхий редактор Хуан Лерма сонирхуулаа. Тархины эд эсийн молекулын түвшинд гарч байгаа аливаа өөрчлөлт хүний зан байдалд ч нөлөөлөх боломжтой. Сонирхолтой нь хүн ухамсарт амьтан, мэдрэхүйн эрхтнүүдийнхээ тусламжтай мэдээлэл хүлээж авдаг тул оптогенетикийн аргаар бус мэдээллээр тархи нь кодлогддог байна. Маркетинг, зар сурталчилгаа, янз бүрийн ухуулгын шинжлэх ухааны үндэслэл нь энэ аж. Тиймээс тархины биологийн үйл ажиллагааг молекулын түвшинд судлах нь нийгмийн эсрэг зан үйл, гэмт хэрэгтнийг засаж, өөрчлөхөд чухал ач холбогдолтой аж. Ялангуяа, хүүхдийг хайрлаж халамжлах нь насан туршийн бэлэг гэж хэлэх дуртай хэмээн Хуан

Лерма онцолсон юм. Өдгөө тархи судлалын шинжлэх ухаанд тулгамдсан асуудал бол улс орнуудын дундаж наслалт нэмэгдэх хэрээр тархины өвчний тоо нэмэгдэж, түүнээс үүдсэн эдийн

засгийн зардал өндөр тусаж байгаа юм. Европын гурван хүн тутмын нэг нь тархины шалтгаант өвчтэй байдаг аж. 2010 оны байдлаар тархины өвчний эмчилгээний зардал 800 тэрбум евро хүрсэн нь

хорт хавдар, чихрийн шижин, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчнөөс давсан дун аж. Долоон секунд тутамд нэг хүн сэтгэцийн эмгэгтэй болж буй бөгөөд 2020 он гэхэд амиа хорлож буй хүмүүсийн

СЭТГЭЦИЙН ЭМГЭГИЙН ЗАРДАЛ

Европын холбоо 2010 онд тархины эмгэгийн эмчилгээний зардалд

€768.8 тэрбум зарцуулжээ

Сэтгэцийн эмгэг	€113.4
Зөнөгрөл	€105.2
Шизофрени	€93.9
Сэтгэл түгших эмгэг	€74.4
Донтолт	€65.7
Цус харвалт	€64.1
Бусад	€252.1

European brain council

БАЙР СУУРЬ



Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл

Тархи судлал бол эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд чухал оролцоотой. Тархины цус харвалт, зүрх судасны өвчин бол монголчуудын нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй. Ялангуяа, эрэгтэйчүүдийн нас баралтын 60 гаруй хувь нь тархины цус харвалт. Харин тархийг судалж, нууц олон боломжийг нэсэнээр тархитай холбоотой өвчлөлийг бууруулах, эмчлэх боломжууд давхар нээгдэнэ. Тиймээс тархи судлал эрүүл мэндийн шинжлэх ухаантай шууд холбоотой юм.



ШУА-ийн ерөнхийлөгч Д.Рэгдэл

Үндсэндээ тархины гүнзгий судалгаа хийх багаж, тоног төхөөрөмжийн хувьд бид 60-70 жилийн өмнөхтэй адил түвшинд явж байгаа. Харин сайн тал нь тархи судлалаар дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад бэлтгэгдээд ирсэн залуу эрдэмтэд маань салбарынхаа бүх мэдээллийг ашиглах чадвартай болсон нь олзуурхуштай. Одоо бид хөрөнгө оруулалт босгож, судалгаандаа орвол дэлхийн түвшинд богино хугацаанд ойртох боломжтой.



Оюун ухааны академийн тэргүүн Х.Хатагбаатар

1981 онд АНУ-ын эрдэмтэн Рожер Сперри хоёр тархи тусдаа үйл ажиллагаатай ч хоорондоо уялдаа холбоотой ажилладаг гэдгийг нээсэнээр Нобелийн шагнал хүртсэн. Харин оюуны спорт бол яг үүнд л тулгуурлаж хөгждөг. Харамсалтай нь манайд тархи судлалын лаборатори, судалгааны бие даасан төвүүд алга. Гэтэл манай тамирчдыг Хонконг, Сингапурт, Хятад, Англи, Германы судлаачид сонирхож, албан ёсоор судалж эхлээд байна.



Ерөнхийлөгчийн орон тооны бус зөвлөх Ж.Амарсанаа

Монгол бол осол гэмтэл, гадаад шалтгаант нас баралтаар маш өндөр орон. Сүүлийн үеийн тархи судлал хиймэл гар, хөл зэрэг тулгуур эрхтнийг хиймэл оюун ухаанаар удирддаг болоход тун амжилттай ажиллаж байна. Тиймээс бид энэ бүх судалгааны ажил руу эрт орж чадах л юм бол үр шимийг нь төдий чинээ хямд хүртэнэ. Мөн бид амиа хорлолтоороо маш дээгүүр орж байна. Энэ бүхнийг тархи судлалыг хөгжүүлснээр харах боломжтой байх болов уу.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Огноо: 2018.09.25

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгуудад тусгай зөвшөөрөл олгож, хууль тогтоомж, тусгай зөвшөөрлийн гэрээний хүрээнд техник стандарт болон хөтөлбөрт нь тодорхой үүрэг хариуцлага хүлээлгэж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилладаг.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдэд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрт тавих хяналтыг сайжруулах, зорилгоор “Телевизийн өргөн нэвтрүүлгийн хяналтын төвийн системийн шийдлийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын тооцоо судалгаа хийж, зөвлөмж боловсруулах” зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Зөвлөх үйлчилгээний нэр: Телевизийн өргөн нэвтрүүлгийн хяналтын төвийн системийн шийдлийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын тооцоо судалгаа хийж зөвлөмж боловсруулах

Зөвлөх ажлын зорилго: Энэхүү зөвлөх үйлчилгээ нь тус хорооноос тусгай зөвшөөрөлтэй Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгийн (Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй 18 өргөн нэвтрүүлгийн телевиз, 52 сувгийн болон 21 аймагт тус тус тусгай зөвшөөрөлтэй 70 телевиз, 9 суваг) нэвтрүүлж байгаа дуу, дүрсийн дохиог Улаанбаатар хотод нэг цэгт хүлээн авч, хөтөлбөрт нь хяналт хийх боломжтой төв байгуулах техникийн шийдлийг боловсруулах, шаардлагатай хөрөнгө оруулалтыг тодорхойлох, хяналтын төвийн техник эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгааг гаргах ажлыг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэхэд оршино.

Хугацаа: Гэрээ байгуулснаас хойш 45-60 хоногийн дотор гүйцэтгэх

Энэхүү зөвлөх үйлчилгээг өргөн нэвтрүүлэг, харилцаа холбооны чиглэлээр туршлагатай, мэргэшсэн зөвлөх баг гүйцэтгэх бөгөөд багийн гишүүд дараах ерөнхий шаардлага хангасан байна. Үүнд:

- Зөвлөх баг нь 2 ба түүнээс дээш гишүүнтэй байх
- Зөвлөх үйлчилгээний баг нь зөвлөх үйлчилгээнд хамаарах өргөн нэвтрүүлэг/ харилцаа холбооны техникийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай, тухайн чиглэлээр мэргэшсэн байх

- Багийн гишүүд нь харилцаа холбоо, өргөн нэвтрүүлгийн чиглэлээр техникийн болон онолын мэдлэг туршлагатай, өргөн нэвтрүүлгийн техникийн шийдэл гаргах, эдийн засгийн тооцоо, судалгаа шинжилгээ хийх ур чадвар, дадлага туршлагатай байх
 - Баримт бичиг боловсруулах, тайлагнах өндөр ур чадвартай байх;
 - Зөвлөх үйлчилгээний чиглэлээр олон улсын туршлага судлах, холбогдох судалгаа шинжилгээ хийх мэргэжлийн англи хэлний зохих түвшний мэдлэгтэй байх;
 - Жич:** Чадварыг нэмэгдүүлж сайжруулах, зөвлөх үйлчилгээг богино хугацаанд, илүү чанартай гүйцэтгэх үүднээс хувь хүмүүс хамтран /түншлэлээр/ оролцож болно.
 - Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх баг нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:
 - Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх хүсэлт, зөвлөх үйлчилгээнд хамаарах ажлыг гүйцэтгэх мэдлэг, ур чадвартай гэдгээ илэрхийлсэн өргөдөл
 - Зөвлөх багийн ахлагч, гишүүдийн танилцуулга, боловсрол, ур чадвар, туршлагын талаарх мэдээлэл, нотлох баримт (мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар, ажлын намтар), холбоо барих утас, цахим шуудангийн хаяг г.м.
 - Зөвлөх үйлчилгээнд хамаарах ажил, үйлчилгээтэй холбоотой болон ижил төстэй ажлын туршлагын талаарх мэдээлэл, хийж гүйцэтгэсэн ажлын жагсаалт
 - Зөвлөх үйлчилгээний ажилд хамаарах техникийн шийдэл гаргах, эдийн засгийн тооцоо, судалгаа шинжилгээ хийх мэргэжлийн ур чадвартайг нотлох тайлбар, танилцуулга гүйцэтгэж байсан ажил үйлчилгээний жагсаалт, үргэлжилсэн хугацаа, байршил зэргийг тодорхой бичих
- Ирүүлсэн мэдүүлэгт үндэслэн саналын урилга болон ажлын даалгаврыг хүргүүлэх зөвлөхийн хураангуй жагсаалтыг гаргаж тус хорооны цахим хуудсаар зарлана. Мэдүүлэг бэлтгэж, ирүүлэхтэй холбогдсон зардлыг зөвлөх өөрөө хариуцна. Сонирхсон этгээд мэдүүлгээ эзвэлж дугуйлан дор дурдсан хаягаар 2018 оны 10 сарын 08-ны өдрийн 16:00 цагаас өмнө ирүүлнэ үү.

Хаяг:
Харилцаа холбооны зохицуулах хороо,
Улаанбаатар хот 14201, Сүхбаатар дүүрэг,
Сүхбаатарын гудамж-13, Бага тойруу, 6 дугаар хороо
Метро бизнес төв, А-корпус, 5 давхар, Зохицуулалтын алба

Утас:
30 42 57
30 42 58
1800 1858
Вэб хаяг: www.crc.gov.mn

Мөнгөний урсгал

Өндгийг алт болгосон энтрепренер

Хамгийн сайн өндгийг хэрхэн гаргаж авахыг Мэтт О'Хайер хүүхэд ахуйгаасаа мэднэ. Харин түүний "Vital Farms" компанийн хувьд худалдан авагч, хөрөнгө оруулагч олох нь хамгийн том сорилт байв.

Клон Сорвино

Нарлаг өдөр Техас мужийн Парис хотоос холгүй орших, 100,000 гаруй ам метр талбайг эзэлсэн гэр бүлийн ферм дээрээ тахиануудтайгаа тоглож буй эрхэм бол Мэтт О'Хайер. Түүнийг нэг тахиа эрхлүүлэхэд бусад тахианууд нь тойрон хүрээлнэ. Мэтт ч "тэдний хэлээр" тэдэнтэй ярилцах аж. Тэрбээр "Сайн охин шүү" хэмээн аман дотроо буйтнаа. "Vital Farm"-ийн үүсгэн байгуулагч, 62 настай Мэтт О'Хайер нарийн зааврын дагуу өндөг үйлдвэрлэдэг 120 бие даасан сүлжээ фермийнхээ нэгээр зочлон шалгаж яваа нь энэ юм.

Түүнийг тахианы байран дундуур явахад 28 цаг тутамд нэг өндөг гаргадаг олон мянган тахиа тус тусын үүрэндээ сууж байв. Хайрцгууд доогуур өндөг цуглуулах үүрэгтэй дамжлага урсан өнгөрөх бөгөөд О'Хайер хайрцаг бүрийн урд унжуулсан хар хөшгийг бахархалтайгаар зааж "Охид нууцлаг байх дуртай" хэмээлээ. "Vital Farms" тахиануудаа ч, ажилтнуудаа ч бусдаас өөрөөр харж, халамжилдаг. Шоотой, улаан цамц, жинсэн өмд өмссөн О'Хайер "Хүмүүс тахиаг өвс



Mongolia
Forbes



ТА ЯГ ОДОО ЗАХИАЛ

УТАС: 77074646

иддэггүй гэдэг. Би ийм яриаг олон жил сонсож байна. "Whole Food" мөн адил зүйл хэлж байсан. Үнэндээ тахиа өвсөнд үнэхээр дуртай" хэмээхдээ хөгжилтэйгөөр бинээж байсан юм. Тэрбээр тахиагаа 75 хувиар цөөрүүлсэн ч орлогоо 35 хувиар нэмэгдүүлэх боломжтой хэмээн фермерүүдийг ятгажээ. О'Хайер "Бид тахиануудаа зоосны нүхээр харахгүй. Харин тэдэнтэй амьд харилцаа үүсгэхийг хичээнэ" гэсэн юм. Өдгөө тэрбээр сүлжээнд нь нэгдэхийг хүссэн олон фермерт татгалзсан харуу өгсөөр байна. Учир нь тэд жилийн турш бэлчээрийн аж ахуй эрхлэх боломжтой хойд Техасаас Миссури хүртэл, зүүнээс Жоржиа хүртэл бүсээ хол байдгай холбоотой.

"Vital Farms" фермерүүдийн хураасан өндгийг шохойн цагаан бичигтэй, тас хар хайрцагт савладаг. Хайрцаг бүрт "Vital Times" хэмээх бичиг сонин байх бөгөөд тэнд тухайн сарын шилдэг тахианы зургийг "Манай охид 'Munchies' чипс авлаа" тэргүүтэй элдэв сонин гарчигтайгаар нийтэлдэг аж. Энэхүү маркетинг болон санхүүжилтийн бүтээлч төлөвлөгөөнийхөө ачаар О'Хайер өндөг үйлдвэрлэлийн салбарт 5 тэрбум ам.долларын зах зээлийг эзэлжээ. Тэрбээр 2007 онд анх гараагаа эхлэхдээ "бэлчээрийн гаралтай" өндөг үйлдвэрлэхээр шийдэж, тахиа тутамд ногдох гадна талбай 33 метр байх стандартыг нэвтрүүлсэн юм (уламжлалт өндгийг жижигхэн торонд чихүүлсэн тахиануудаас гарган авдаг бөгөөд "торноос чөлөөлөх" гэдэг нь ямар ч тор ашиглахгүй, "чөлөөт хүрээлэл" гэдэг нь нэгж тахианд 1.8 ам метр талбай ногдохыг илэрхийлдэг). Энэ нь түүний бусад олон шийдвэрийн адил ашигт нь сөргөөр нөлөөлөхийг мэдэж байв. Тухайн үед бэлчээрээс гаралтай өндөг зах зээлийн 0.1 хүрэхгүй хувийг эзэлж байсан. Харин өнөөдөр энэ тоо 2.7 хувь болж өссөний 73 хувь нь О'Хайерын Остинд байрладаг "Vital Farms"-аас гаралтай. Өдгөө 110 ажилтантай тус компани өнгөрсөн жил 100 сая ам.долларын борлуулалт хийсэн нь 2016 онтой харьцуулбал 30 гаруй хувиар өссөн дүн

юм. Тэд "Whole Foods"-ээс ч давсан өсөлт үзүүлэхийн сацуу 12 ширхэгт 8 ам.доллар төлж чадах ("Walmart"-ийн хамгийн хямд өндөгнөөс даруй дөрөв дахин өндөр үнэ) "Amazon Fresh", "Kroger", "Walmart", "Target" тэргүүтэй томоохон үйлчлүүлэгчдийг татах аргаа олжээ. "Whole Foods"-ийн ерөнхийлөгч Галло "Бидний төсөөлж байснаас хавьгүй том юм" гэв.

Рөүд-Айлендад өсөж том болсон О'Хайерт айлуудаар явж өндөг зарвал коллежийн зардлаа хийж чадна гэж авга ах нь байнга хэлдэг байж. Тэрбээр 1968 онд 13 насны төрсөн өдрийнхөө өмнөхөн хувийн өндөгний бизнесээ эхлүүлжээ. Эцэст нь оюутан болох насан дээрээ О'Хайер бодлоо өөрчилж энтрепренер болохоор шийдэж, амжилт олно гэж үзсэн хэд хэдэн бизнесийг эхлүүлжээ. Тэрбээр Хьюстонд ирж, барилгын цэвэрлэгээний компани байгуулсан ч 1980 онд түүнийгээ хэдэн зуун мянган ам.доллараар худалсан. Тэр мөнгөөрөө ферм худалдан авч, тэндээ гурван жил тахиа үржүүлсний эцэст жижиг бизнес эрхлэгчдэд бартерын замаар зардлаа хэмнэхэд нь тусалдаг компаниа санхүүжүүлэхийн тулд газрынхаа зарим хэсгийг худалджээ.

1995 онд тэрбээр цаг нь тулсан үед хоноглох буудал хайдаг нислэгийн ажилтнуудад чиглэсэн "Grand Adventures Tour & Travel Publishing" хямдралтай аяллын компаниа үүсгэн байгуулав. Тус компани 50 сая ам.долларын орлоготой болж, 1998 онд хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжээ. Гэвч 2001 онд түүнийг хөрөнгө босгохоор Манхэттенд аялах зуур Дэлхийн худалдааны төвийн ихэр цамхаг нуран унаж, олон захилга нь ар араасаа цуцлагдав. Хоёр цагийн дотор худалдахад хүрсэн бөгөөд уг явдлаас нэг зүйлийг сайтар ойлгож авсан гэдэг. "Үргэлж хэрэгцэнээс давсан хөрөнгөтэй бай". Дараах таван жилд нь тэрбээр одоогийн гэргий, тухайн

үеийн найз бүсгүйтэйгээ хамт дарвуулт завин дээр амьдарч, түүгээрээ аялагчдад үйлчилж амьдарч байв.

Тэд 2007 онд О'Хайерын сайн найз, "Whole Foods"-ийн үүсгэн байгуулагч Жон Макейн төрөлх нутаг Остин хотноо нүүж иржээ. Удаах жил нь О'Хайер "Whole Foods"-ийн захирлуудын хамт Индонезид усанд шумбах аялал хийх зуураа хүнсийг илүү хүнлэг байдлаар гаргаж авах тухай маш ихийг сонсож мэджээ. Тэрбээр тахианууд өвсөөр хооллох үед өндөг нь илүү амтлаг болж байсныг санаж, ахин нэг удаа бизнесийн салбарт хүчээ сорихоор шийдэв. О'Хайер Рөүд-Айлендын улаан үүлдрийн 20 тахиа, Остинд 110,000 ам метр газар худалдан авч, бүсийнхээ зоогийн газар, фермерүүд цуглардаг худалдааны төвд өндөг нийлүүлж эхэлсэн аж. Түүний хэлсэн үнээр өндөг худалдаж авах хүн цөөн байсан тул ихэнхийг нь хүнсний тусламжийн төвд хандивлахад хүрч байв. Одоо ч 2005 оны "Subaru"-аар хуурт хийж буй О'Хайер "Би өндгөө хямд зарж чадаагүй. Урт хугацааны үнэ тогтоохыг хүссэн" гэв. 2008 онд "Whole Foods" түүний өндөг-нүүдийг төвийн мужуудаар худалдаж эхэлсэн юм. О'Хайер "Тэд манай бүтээгдэхүүнийг худалдаж эхэлсэн нь тэдний хувьд том эрсдэл байсан. Тэд манайхыг дэлгүүртээ шилдгээр шалгаруулж, ангилал тогтоож байлаа" гэв.

Хөдөө аж ахуйн практикийг хэрэглэгчдэд таниулах хөдөлгөөний үеэр "Vital Farms"-ийн үйл ажиллагаа эхэлсэн нь азтай хэрэг болжээ. О'Хайер борлуулалт өсөхийн хэрээр өндөг хураахаас илүү сурталчлах хүнсний сүлжээ улсын О'Хайер 2013 оны үерт Остин дэх фермээ алдсанаа дараа маркетингийн ажилд төвлөрөх болж, улмаар газраа худалдахад хүрвэ. Маркетингийн шинэ санаачилгууд нь ан амьтдын туршлагатай зураглаачийг брэнд хариуцсан захирлаар авах,

нөлөө бүхий хэвлэл мэдээллийн салбарынхантай зоогийн, тусгай арга хэмжээ зохион байгуулах, 2017 онд "YouTube"-ээр цацагдсан "Bullsh*t Free Eggs" цуврал (2.7 сая удаа үзсэн), "Bullsh*t Free Kitchens" цуврал (2.4 сая удаа үзсэн) зэрэг кампанит ажил байв. Гол зорилго нь миллениал залуустай холбоо тогтоох бөгөөд "тэнд л салбар хамаарахгүй өсөлт гардаг" гэж О'Хайер хэлсэн юм.

● Тэрбээр тахиагаа 75 хувиар цөөрүүлсэн ч орлогоо 35 хувиар нэмэгдүүлэх боломжтой хэмээн фермерүүдийг ятгажээ.

● О'Хайер 2013 оны үерт Остин дэх фермээ алдсанаа дараа маркетингийн ажилд төвлөрөх болж, улмаар газраа худалдахад хүрвэ.

● 4000 гаруй супермаркетэд нийлүүлж, жилд 18 сая ам.долларын орлого олж байна.

О'Хайер "Pitchbook"-ийн саяхны тооцоогоор 136 сая ам.долларын үнэлгээтэй компанидаа үнэг цаас гаргаж, 25 сая ам.доллар босгон "Vital Farms"-ийн өсөлтийг хурдасав. Үүний дийлэнхийг ачааны автомашин, нэмж "Subaru" худалдаж авахад зарцуулсан төдийгүй 17 сая ам.долларыг нь өнгөрсөн намар Миссуригийн Спрингфилд хотод "Vital Farms"-ийнхан "өндөгний төв зогсоол" гэх угаах, савлах байгууламжийг зэрэгцээ өсөлтөд шаардагдах хөрөнгө босгох боломжийг бүрдүүлсэн байна.

Үнэт цаасны зургаан хөрөнгө оруулагч дунд богино хугацааны ашиг харсан хүн нэг ч байхгүй

хэмээн О'Хайер хэлсэн билээ. Тэд өгөөжөө хүртэлгүй хүлээх хүсэлтэй төдийгүй тэдний хэн нь ч О'Хайерыг компани зөвхөн ашгийн төлөө бус, нийгэмд ээлтэй гэсэн статустай болгоход эсэргүүцээгүй билээ. Эдгээр нь байгаль орчны тогтвортой байдал зэрэг зүйлсийг тэргүүлэх чиглэлээ болгохыг шаарддаг бөгөөд улмаар компанийн ашиг сонирхол, үнэлэмжийг хязгаарлаж болох юм. О'Хайер "Хамгийн өндөр үнэ хэлсэнд нь худалдах албагүй" гэв. Хөрөнгө оруулагчдад зориулсан арга хэмжээ нь компанийн хамгийн том хувьцаа эзэмшигч хэвээр үлдсэн О'Хайерыг хөндлөнгийн оролцоо болон санхүүжилтийн үе шатыг дагаж хувьцааны ханш өсөхийн хэрээр хөрөнгө оруулагчид хувьцааныхаа зарим хэсгийг борлуулах эрсдэлээс хамгаалах хэрэгсэл болж байгаа юм. Тэрбээр "Минийх шиг алхам хийсэн өөр бусад компанийг мэдэхгүй. Одоогийн хувьцаа эзэмшигчдэдээ хөрвөх санал тавих санаа нь нийгмийн ухаасартай бизнес босгох хүслээс үүдэлтэй. Үүнээс улбаалж би хувьцаа эзэмшигчдэдээ хувьцаагаа аж ахуйн нэгжийн борлуулалтад дарамт болохгүй байдлаар, бүхэлд нь эсвэл хэсэгчлэн зарах сонголтыг олгоход хүрсэн" гэв. Одоогийн байдлаар хэн ч худалдаагүй байна.

Хэдий тийм боловч "Vital Farms" өдгөө долоо хоног тутамд таван сая ширхэг өндөг тээвэрлэхийн зэрэгцээ уламжлалт хэрэглэгчдийг татах үүднээс зардал танах тал дээр анхаарч ажиллаж байна. Тухайлбал, фермерүүдийн сүлжээнээс өдөр бүр, тухай өдөртөө багтааж бүх өндгийг татан тээвэрлэдэг "Egg Central Station" төвийн тусламжтайгаар "Vital Farms" хайрцаг бүрээс 20 цент хэмнэж байна. Түүнчлэн органик нь баталгаажуулсан өндөг худалдах замаар үнээ бууруулах болжээ. Тахианууд пестицидийн агууламжгүй, органик бэлчээрийн өвсөөр хооллодог хэдий ч тэдний тэжээлд генетикийн өөрчлөлттэй эрдэнэ шиш хольсон аж (Саяхан гэдэсний халдварт өвчин гарсны улмаас бүтээгдэхүүнээ эргүүлэн

татах ажиллагаанд "Vital Farms" хамааралгүй).

Үнэ, органик чанарыг чухалчлах болсны хэрээр "Vital Farms"-ийн өрсөлдөгч нэмэгдсээр байна. Тэдний нэг бол бэлчээрийн гаралтай, органик өндөг үйлдвэрлэгч "Handsome Brook Farms" юм. "Vital Farm"-ийг байгуулагдсан жил Нью-Йоркийн хойд хэсэгт үүсгэн байгуулагдсан "Handsome Brook Farms" бүтээгдэхүүнээ "Kroger", "Publix" тэргүүтэй 4000 гаруй супермаркетэд нийлүүлж, жилд 18 сая ам.долларын орлого олж байна. "Handsome Brook Farms"-ийн дийлэнх өндөг органик бөгөөд тус компанийн санхүүжүүлэгчдийн нэг Гари Хиришберг "Vital Farms"-ийн нэршил хэрэглэгчдийг төөрөгдүүлж байх талтай гэв. "Lactalis" нэгдлийн эзэмшилд байдаг "Stonyfield Organic" гарганы бизнесийг хамтран үүсгэн байгуулсан тэрбээр "Vital Farms" органик гэсэн нэршил дээрээ илүү сайн ажиллах хэрэгтэй. Хэрэглэгчид үүнийг л хүсдэг. Компаниуд шошго дээрээ тахианы саравчны зураг наагаад л бүтээгдэхүүнээ "натурал" болгон хувиргаж байна" гэв.

О'Хайер хариуд нь "Бид боломжийнхоо хэрээр нээлттэй байхад анхаардаг. Хэрэв шошго дээр 'органик бус' гэж бичихийг бидэнд зөвшөөрсөн бол бичих л байсан" гэв. Тэрбээр "Vital Farms" органик цувралаа өргөжүүлж буй тухайгаа нэмж хэллээ. О'Хайер "Бид анхнаасаа 100 хувь органик байсан. Гэвч бид тэлэх явцаа харьцангуй бага орлоготой хэрэглэгчдэдээ хүрэх хэрэгтэй болохыг ойлгож улмаар зардлаа танах хэрэгтэй болсон. Энэ шийдвэр зөв байсныг зах зээл батлан харуулсан" гэв.

Эхний улирлын байдлаар борлуулалт 47 хувиар өссөн хэмээн О'Хайер өгүүллэв. Тэрбээр бэлчээрийн үхрийн сүүнээ цоцгийн тос гаргаж авах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд "Vital Farms" өдгөө түүний хүлээлтээс даван өргөжиж буй тухай бодолдоо инээмсэглэх ажээ. Тэрбээр "Намайг ашиг хөөхөө болимогц маш их мөнгө гарч ирсэн. Тэр бол миний амьдралдаа үзсэн хамгийн том амжилт" гэв. **Forbes**

ZGM DAILY

Millenium Challenge Corporation to grant USD 350 million

IMF warns Mongolia to cut fiscal deficit and increase FX reserve.

Neuroscience - XXI Century Conference takes place

Nobel Prize winner Edvard Moser delivers a lecture themed Time and Space.

Parliament announces agenda for Autumn Session

Key discussions include revision to taxes and legal status of the Municipality.

Top 20 Index falls 0.39 percent, to 19,864.79 points

Market cap stands at MNT 2.33 trillion.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

The high-level General Debate of the 73rd United Nations General Assembly will commence today. Prime Minister of Mongolia Khurelsukh Ukhnaa is expected to attend the 9-days debate.

Minister of Defense Enkhbold Nyamaa is on a visit to the Federal Republic of Germany, during which the Minister visited 232nd Mountain Infantry Battalion in Bischofswiesen, Bavaria.

Chief of Staff of the President's Office Enkhbold Zandaakhuu receives the international neuroscientists, participants of the conference. Sides exchanged views on opportunities for cooperation with international scientists in brain research in Mongolia and possible studies.

ECONOMY

Material Impex JSC announces an irregular board meeting on November 02 to discuss the establishment of a fully owned non-banking financial institution, as well as related regulations.

Top 20 Index falls 0.39 percent, to 19,864.79 points. MSE A Index falls 0.55 percent, to 9,480.02 points. MSE B Index decreases 0.58 percent, to 8,910.71 points. Market cap stands at MNT 2.33 trillion.

SOCIETY

According to statistics, traffic accidents reduced by 11.3 percent in the Capital compared to the same period of last year.

Eagle huntress Aisholpan Nurgay stars in the Nomads documentary series of the Kazakhstan Radio and Television Corporation. The documentary series will broadcast in Kazakhstan starting from October 14.

Mongolian women's wrestling team wins two silver and one bronze medals and men's team claims one silver medal from the United World Wrestling Junior World Championships, held in Trnava, Slovakia.

The Autumn Grand Sumo Tournament 2018 Aki Bashi ended on September 23. Hakuho Davaajargal Munkhbat set a new record with the 1,000th victory in the top division beating Ozeki Goeido in the bout on the 14th day.

PM meets representatives of key international organizations

Millennium Challenge Corporation concerns over water supply in Ulaanbaatar city

Tugsbilig.B
@tugsbiligZGM

Prime Minister of Mongolia Khurelsukh Ukhnaa, during his visit to the United States of America, met with the Heads of the World Bank Group, International Monetary Fund (IMF) and representatives of Millennium Challenge Corporation.

Jim Yong Kim, President of the World Bank Group, expressed his satisfaction towards economic recovery of Mongolia following the joint programs and policy measures.

Prime Minister Khurelsukh noted that the Government of Mongolia is giving special importance in expanding the first phase of Economic Management Program and efficiently implementing its second phase. He then announced to focus on intensifying joint projects, stabilizing the economy and increasing accessibility.

IMF WARNS TO INCREASE FX RESERVE

On the same day, the PM Khurelsukh discussed the results and further actions of Extended Fund Facility (EFF) program with Christine Lagarde, the Managing Director and Chairwoman of the IMF.



Jim Yong Kim, President of the World Bank Group



Brock Bierman, Acting Chief Executive Officer of the Millennium Challenge Corporation



Christine Lagarde, Managing Director and Chairwoman of the IMF

Ms. Lagarde expressed contentment towards successful implementation of the program thanks to Mongolia's strong commitment to the program, fiscal stability, and significant progress on reducing debts and upgrading credit ratings, highlighting that the implementation of the EFF remains satisfactory with key targets met.

Thanks to the program, Mongolia's economy grew 6.3 percent in the first half of 2018 from 1.2 percent in 2016 and the IMF expects 8 percent growth in 2018. However, Ms. Lagarde warned that Mongolia remains vulnerable to external and internal shocks and signified the necessity to create favorable en-

vironment for investment, reduce fiscal deficit and further increasing FX reserve, and advised Mongolia to outline preparatory actions for potential shock.

MILLENNIUM CHALLENGE CORPORATION ADDRESSES WATER SUPPLY IN UB

On the sideline meeting with the delegation of Millennium Challenge Corporation, the Prime Minister had an au fait with the Millennium Challenge Corporation's plan on improving water supply in Ulaanbaatar city.

According to Kumar Ranganathan, Practice Lead and Senior Director for Water and Sanitation


Infrastructure at the Millennium Challenge Corporation, the water supply in Ulaanbaatar city has reached a level of concern. Ulaanbaatar city has less than 20 years of water supply with the current methodology for surface and deep water consumption. The runoff of Tuul river, the key source of drinking water in Ulaanbaatar, is in danger of diminishing several times than the normal size. Therefore, the Millennium Challenge Corporation settled USD 350 million in non-refundable aid for a project on a 5-year comprehensive solution to water supply issues. "We hope the implementation of this project will have multiple positive impact

on Mongolia's socio-economic situation," remarked Mr. Kumar Ranganathan.


The project will be implemented in three phases between 2019 and 2023, increasing and cleansing deep water reserve, as well as installing filters, in 50 locations. Within the frame, a water purifier will be established, which will also allow industries to use greywater. For instance, thermal power plants will have annual access to 15 million square meters of greywater. Purifying technology will be installed in ger district drinking water wells, which is estimated to save 70 million square meters of water reserve. [ZGM]

STOCK MARKET


Khuvsgul Altan Duulga JSC (by units)



LendMN NBFJ JSC (by units)



Mongolian Post JSC (by units)



ZGM:QUOTE

Edvard Moser: We are close to curing neurodegenerative diseases like alzheimer



Nobel Prize holder Edvard Ingjald Moser delivers a speech at the Neuroscience - XXI century conference.

Edvard Ingjald Moser, a Norwegian psychologist and neuroscientist, who won a Nobel Prize in Physiology or Medicine in 2014, delivered a lecture themed Time and Space at the Neuroscience - XXI century conference took place yesterday under the auspices of the President of Mongolia.

"The human brain has almost 100 billion neurons and each of those makes about 10,000 connections, known as synapses, and send electrical signals via neurotransmitters.

This is the main function of human and mammal brains. By thoroughly studying this, we can cure mental illnesses that are becoming a global issue, such as alzheimer.

Scientists studied the navigation systems of rat, monkey and human brains. The human brain has two structures that operate as a navigation system and are located behind the ear. As a test, scientists put a rat in a maze with and without obstacles to study how they mapped the environment. Around 1930's,

scientists believed that brains had maps of local space that coordinates with the environment and information about objects. However, the theory was hard to prove due to lack of technology. There has been some progress made in 1950's; for instance, microelectrodes were invented. These are used to penetrate cell membrane and allowed an opportunity to register information in neurons.

This was the beginning of many studies, such as the transmission

of nerve cell information, which allows to change the behavior animals except the human. It was then discovered that we do not receive spatial signals from our eyes or ears like other animals, this is something that is constructive in the brain called Optogenetics. In other words, we only need the give the necessary information to humans to make them understand white is a color and picture of a cow is a cow. This is the basis of marketing, advertisement and propaganda studies.

However, scientists have not studied much about the information related to time. In any case, humans record a certain amount of time. These are only the first stage of cognitive learning. By further studying the brain, we are close to the future where we will cure alzheimer and other neurodegenerative diseases. Symptoms of alzheimer is the malfunction in their navigation mechanism. Study shows that one percent of global population suffers from this disease." [ZGM]

POLITICS

Parliament adopts Autumn Session Agenda

Parliament Speaker Enkhbold Miyegombo has issued the agenda for the Autumn Session of the Parliament.

The Agenda for the Autumn Session of the Parliament:

- ✓ 2019 State Budget;
- ✓ 2019 Budget of Social Insurance Fund;
- ✓ 2019 Budget of Health Insurance Fund;
- ✓ Approval of 2019 Monetary Policy Guidelines;
- ✓ Revision to the General Law on Taxation;
- ✓ Revision to the Law on Corporate Income Tax;
- ✓ Revision to the Law on Supporting Small and Medium Enterprises and Services;
- ✓ Revision to the Law on Personal Income Tax;
- ✓ Law on Investment Banking;
- ✓ Amendments to the Law on Government Special Funds;
- ✓ Amendments to the Law on Procurement of goods, works and services with state and local funds;
- ✓ Amendments to the Constitution;
- ✓ Bill on Parliamentary Election;
- ✓ Bill on Presidential Election;
- ✓ Bill on Citizens' Representative Khural election of aimag, capital city, soum and district;
- ✓ Amendments to the Law on Political Parties;
- ✓ Revision to the Legal Status of the Municipality;
- ✓ Revision to the Labor Code;
- ✓ Bill on Supporting Reproduction;
- ✓ Amendments to the Criminal Code;
- ✓ Amendments to the Law on Violation;
- ✓ Bill on Drug and Alcohol Intoxication by Administrative Procedures;
- ✓ Amendments to the Law on Water Pollution Control;
- ✓ Revision to the Law on Prevention of Crime and Violation.

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР



- 07.00** Өглөө хөтөлбөр
- 14.00** Ухаарч амьдрах хорвоо" олон ангит уран сайхны кино 13,14-р анги
- 17.25** Улсын баруун хил дээрх зэвсэгт тулгаралт дууссаны 70 жилийн ойд "Босго тогто" Монголын уран сайхны кино 40-р анги
- 19.00** Хөрөнгө оруулалт ба бизнесийн орчин
- 20.00** "Цагийн хүрд" мэдээллийн хөтөлбөр /шууд/
- 21.10** Цаг үе, үзэл бодол /шууд/

Bloomberg TV Mongolia

- 09.00** "Бизнесийн хэмнэл" хөтөлбөр
- 14.00** "Бүрэн тайлбар" нэвтрүүлэг
- 15.00** "Бизнесийн төв цэг" хөтөлбөр
- 20.00** #MadelnMongolia" нэвтрүүлэг

- 21.00** "Мөнгөний урсгал" хөтөлбөр
- 22.30** "Хариуцлага ба үнэ цэнэ" нэвтрүүлэг

БОЛОВСРОЛ HD

- 07.20** "Бяцхан оцон шувуу Пороро" хүүхэддэйн кино 1-1-6-р анги
- 09.00** "Монголчууд ХХ зууны эхэнд" нэвтрүүлэг
- 14.05** "Та 5 дугаар ангийн хүүхдээс ухаантай юу?" шоу нэвтрүүлэг
- 16.45** "Дэлхийн атлас" нэвтрүүлэг
- 22.00** "Ээж" ОАК 19-р анги
- 23.05** "Көсем" ОАК 1.75-р анги

МОНГОЛТВ

- 07.00** Өнөө өглөө
- 12.00** Хөтөч мэдээллийн хөтөлбөр
- 14.30** Монгол тулгатны 100 эрхэм-Б.Чимэд
- 18.00** "Тог тог тог" /season-6/ 26-1-р хэсэг
- 19.00** Оргил цаг мэдээллийн хөтөлбөр
- 21.30** 24" ОАК /season-4/ 20-р анги

ЗУРХАЙ



Билгийн тооллын 15
Намрын дунд цагаагчин тахиа сарын найман цагаан мэнгэтэй цагаан бич өдөр.
Үс засуулбал: Өлзийтэй сайн
Наран ургах, шингэх: 06.44-18.42
Барилдлага: Үхэх
Шүтэн барилдлага: Хуран үйлдэхүй
Суудал: Ус

Аргын тооллын есдүгээр сарын 25, Ангараг гараг. Билгийн тооллын давхарласан 15, Могойг хүлэгч одтой, цагаан бич өдөр.
Өдрийн наран 06.44 цагт мандаж, 18.42 цагт жаргана. Тухайн өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, сан тавиулах, угаал үйлдэх, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, хур оруулах, дарханы үйлд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, сэтгэлд сэвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.



"Чөлөөт хос" инээдмийн жүжиг
Хэзээ: 2018.09.26-ны 19.00 цагт
Хаана: УДЭТ
Тасалбарын үнэ: ₮ 10-20 мянга



Grandeur модерн балет
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2019.09.28-ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮30-40 мянга



"Гоё кап" волейболын залуучуудын УАШТ
Хэзээ: 2018.09.29-10.03
Хаана: Спортын төв ордон
Тасалбарын үнэ: ₮ 3-10 мянга

ОНЦЛОХ ҮЗВЭР

"Люмино"-гийн 20 жилийн ойн тоглолт



Анхны уран бүтээлээ 1998 оноос сонсогч олондоо хүргэсэн "Люмино" хамтлаг 20 жилийн ойн тоглолтоо хийх гэж байна. Тэд өнгөрсөн хугацаанд 100 гаруй дуутай болсон бөгөөд ихэнхийг нь дүрсжүүлээд байгаа юм. "Люмино" хамтлагийн гишүүн Бажи буюу Б.Батхишиг өөрийн

facebook хуудаснаа "Манай хамтлаг одоогийн урлагийн залуусын үүд хаалгыг нь нээн өгч урлагт гарч ирэхэд нь илүү амархан болгож өгсөн гэдэгт итгэдэг. Мөн сонсогч нартаа зөв бас гоё хөгжмийн боловсрол олгосон байх гэж боддог. Бидний шинэ уран бүтээлүүд ар араасаа

гарч, таны сонорыг мялаасаар байх болно" хэмээн бичжээ. Тэдний 20 жилийн үнэнч нөхөрлөл, анд нөхдийн нандин дурсамжаар аялуулах тоглолт аравдугаар сарын 19, 20-ны 19.00 цагт Crocus Event Hall-д болно. Тасалбарын үнэ 40 мянган төгрөг. [ЗГМ]



"Сэтгэл догдлуулсан орой" тоглолт
Хаана: Corporate Convention Centre
Хэзээ: 2018.09.28-29-ний 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 40-60 мянга



"Тамгагүй төр" түүхэн жүжиг
Хаана: УДЭТ
Хэзээ: 2018.10.6, 7-ны 18.00 цагт
Тасалбарын үнэ: ₮10-25 мянга



"Би эндээс явахгүй" драмын жүжиг
Хэзээ: 2018.10.12-14
Хаана: УДЭТ
Тасалбарын үнэ: ₮ 10-25 мянга

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

1	2	3	4	5	6
7		8		9	10
11	12	13	14	15	
16					

- 13. ...хатан чанар
- 14. Хөдөө аж ахуйн нэгэн чухал салбар (товчилсон нэр)
- 15. Хөгжмийн аяны тэмдэглэгээ

- дуу" гэгдсэн дуу
- 7. Оросын нэрт уран зураач
- 9. Бодлогын нэгэн үйлдэл
- 11. Хошин урлагийн жүжигчин, МУГЖ
- 14. Харуул
- 16. Дэлхийн том уралдаан наадмуудад түрүүлсэн нэрт дуучин, МУГЖ

Хөндлөнгөөр:

- 1. Алдарт хөгжмийн зохиолч З.Батсүхийн зохиосон "Хаврын сүлд

Өмнөх дугаарын хариу / 09.24

Х	Ч			А	Х							
А	Т	А	А	А	М	У	У					
Х	У	Л	С	Н	Ы	Б	А	А	В	Г	А	И
Б	М	У	Э	Л	А	Н						
А	Ю	У	Ш		П	А	Я	Н				
Г	Р				Н	А						

БОСООГООР:

- 1. Бараг бүх эрхтэн нь эм болдог, "оточ" гэгдсэн мэрэгч амьтан
- 2. Тансаг, тусгай үйлчилгээний өрөө
- 3. Тун маш гэсэн үг
- 4. Нар сарыг залгадаг

- хэмээх домгийн амьтан
- 5. Шилний түүхий эд
- 6. "Хоовон" хэмээх хочтой хөгжмийн зохиолч
- 8.
- 10. Телевизийн нэгэн алба (товчилсон нэр)
- 12. Румыний мөнгөний нэгж

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	IX.25	IX.26	IX.27	IX.28	IX.29
	19° / 6 м/с 5° / 5 м/с	19° / 9 м/с 7° / 6 м/с	9° / 14 м/с 5° / 9 м/с	3° / 12 м/с -2° / 12 м/с	7° / 8 м/с -1° / 8 м/с
	Үүлшинэ	Бага зэргийн хур тунадас	Цас	Бага зэргийн цас	Ялимгүй цас




ФОТО АГШИН



Б.Батдорж / ЗГМ

ЗГМ: СУДОКУ

	5		7	6		
	4		6			
			1		8	3
6	7		8			2
			9	4		
					9	7
		3				
8	2					6
4	6					1

2	8	3	6	4	1	7	5	9
4	1	7	2	9	5	3	6	8
9	6	5	7	3	8	2	4	1
3	5	6	4	8	9	1	7	2
1	2	9	3	7	6	5	8	4
8	7	4	5	1	2	6	9	3
6	9	1	8	5	3	4	2	7
5	4	8	1	2	7	9	3	6
7	3	2	9	6	4	8	1	5



ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-МОСКВА	13.50	14.28
МОСКВА-УБ	21.35	07.30
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-СҮХБААТАР	21.15	05.12
СҮХБААТАР-УБ	20.55	05.03
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48



НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-БЭЭЖИН	00:00	00:40
БЭЭЖИН-УБ	01:40	04:10
УБ-ХОНКОНГ	06:25	10:55
ХОНКОНГ-УБ	12:05	16:45
УБ-СӨҮЛ	08:40	12:50
СӨҮЛ-УБ	14:20	17:00
УБ-БУСАН	08:35	11:40
БУСАН-УБ	12:50	17:00
УБ-ТОКИО	07:45	13:40
ТОКИО-УБ	14:40	19:15
УБ-БИШКЕК	04:15	10:05
БИШКЕК-УБ	11:05	13:30
УБ-МОСКВА	07:10	08:45
МОСКВА-УБ	19:00	00:00

Их Британийн компаниуд хувьцаанаасаа ажилчдадаа эзэмшүүлж магадгүй байна

Британийн түүхнээ хамгийн интервенционист бодлогын нэгийг сүүдрийн сангийн сайд танилцууллаа. > 10

Barrick, Randgold хоёр \$18 тэрбумаар нэгдэнэ

Нийт 18 тэрбум ам.долларын хэлцэл амжилттай өндөрлөвөл дэлхийд тэргүүлэх алт үйлдвэрлэгч шинээр үүснэ. > 10

Хонконг Хятадын суман галт тэрэгний сүлжээнд холбогдлоо

Хонконгийн БНХАУ-тай холбож буй шугам нь уг дэд бүтцийг дэмжигч, гүтгэгч нарын аль алинд утга учиртай. > 10



BBM©

► Дэд бүтцийн сангууд томорч байна



Питер Смит
Дэлхийн эдийн засгийн ноён нуруу болох дэд бүтцийн хөрөнгө оруулалтын эрэлт өсөж байгаа. Энэ үед хөрөнгийн менежерийн хоёр сан тус бүрдээ 20 тэрбум ам.доллар босгохыг эрмэлзэж байгаа нь бүртгэгдээгүй сангууд дотор тэргүүлэх боломжийг бүрдүүлнэ. 285 тэрбумын хөрөнгө эргүүлдэг Brookfield сан 2016 онд дэд бүтцийн зориулалтаар босгосон 16 тэрбумаа зарцуулж дууссан тул ойрын саруудад шинээр 20 тэрбум ам.доллар босгохоор төлөвлөж байна. Түүнчлэн Global Infrastructure Partners сан зөвхөн өнгөрсөн онд 15.8 тэрбумыг босгож дээд амжилт тогтоосон бол дахиад 20 тэрбумыг 2019 оны эхээр босгохоо зарлав. Хоёр сан хоёул мөнгө босгох төлөвлөгөөгөө биелүүлж чадах байх гэж эх сурвалж ярилаа.

► АНУ-ыг дайн эхлүүлээ гэж буруутгав



Катрина Мансон
Ираны Ерөнхийлөгч Хассан Рухани НҮБ-ын Ерөнхий ассамблейд Трампын хоригийн эсрэг үг хэлэхээр мордохын өмнө "АНУ, Исламын тогтолцооны эсрэг дайн эхлүүлээ" хэмээн буруутгажээ. Тэрбээр цэргийн парад дээр хэлсэн үгэндээ АНУ 1980-аад оны Иракт болсонтой адил бус нутгийн улсуудаар дамжуулан хуйвалдаан хийхээ больж, Иран үндэстэнд шууд заналхийлж байна гэв. Түүний хэлснээр Вашингтон цөмийн гэрээний асуудлаар бус Исламын тогтолцоог эвдэхийн тулд дайн эхлүүлсэн гэнэ. Ноён Рухани Исламын улс бууж өгөхгүй мэдэгдээд "Өнөөдөр өрнөдийн ба дорнын улсууд бидэнтэй хамт, АНУ-ыг буруушааж байгаа. Бид Трампыг ялах болно" гэж мэдэгдэв.

Хятадыг сөрөхийн тулд АНУ \$60 тэрбумыг зарцуулна

ОРИС-ын зээлдүүлэх хязгаарыг хоёр дахин нэмж, 60 тэрбум ам.долларт хүргэнээр хувьцаанд хөрөнгө оруулах боломжийг нээж, бусад хөгжлийн сангуудтай адил түвшинд ажиллах аж. Шинэ зах зээлийн асуудлаар зөвлөдөг, Вашингтонд байрлалтай KRL фирмийн захирал Рива Левинсон уг төслийг 11 дүгээр сард болох Конгрессын завсрын сонгуулиас өмнө батална гэдэгт найдаж буйгаа мэдэгдэв.

Тэрбээр "Энэ бол АНУ өөрийн компаниудаа хөгжиж буй орнууд дахь арилжааны байлдаанд дэмжих ёстой хүлээн зөвшөөрсөн анхны бодит алхам. Учир нь Хятад улс бүгдийг хамчихаад

Ноён Вашборн энэ талаар "Хятадын төрийн компаниуд гадаад бодлогынх нь нэг хэсэг болж, Хятадын төрийн эрх ашгийн үүднээс ажиллаж, хяналтаа өргөжүүлж байна" хэмээн сэрэмжлүүлэв.

байгаа" хэмээв. Хөрөнгө оруулалтыг хөгжилд ашиглах тухай хуулийг наймдугаар сард төлөөлөгчдийн танхимаар батлахад хоёр намын төлөөлөл хоёул дэмжсэн юм. ОРИС-ыг өөрчлөн Олон улсын хөгжлийн санхүүжилтийн корпорац болгон зохион байгуулна. Уг хуулийн төслийг боловсруулахад оролцож байгаа хүмүүсийн ярьснаар энэ алхам хувийн салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих, Хятадын өрийн дипломат арга барилыг төлөгчдөд орлого оруулах зорилготой гэнэ.

Наймдугаар сард 16 сенатч хамтран Сангийн сайд Стивен Мнучинд илгээсэн захидалдаа

"Олон улсын валютын сан Хятадын дэд бүтцийн гэгдэх мөлжигч зээлийн улмаас хүндрэлд орсон улсуудыг аврах ажиллагаа явуулж байна" хэмээн шүүмжилсэн. Уг захидалд хятадууд Африкийн Жибути улсын ачааны боомтыг эрхэндээ авсныг дурдсан. Өнгөрсөн онд Бээжин гадаад дахь анхны цэргийн баазаа Улаан тэнгисийн эрэгт Жибутийн нутагт байрлуулсан. Ноён Вашборн энэ талаар "Хятадын улсын компаниуд гадаад бодлогынх нь нэг хэсэг болж, Хятадын төрийн эрх ашгийн үүднээс ажиллаж, хяналтаа өргөжүүлж байна" хэмээн сэрэмжлүүлэв.

Зарим улс Хятадын зээлийн

арга барилд эргэлзэж эхэлсний дотор долдугаар сард Малайз 22 тэрбум ам.долларын өртөгтэй Хятадын дэмжлэгтэй төслийн санхүүжилтыг эргэн шалгахар болсон. Африкийн зарим орны иргэд Хятадын зээлийг улс орноос илүү авлигач түшмэдүүдэд ашигтай гэж шүүмжилдэг. Ганын Ардчилсан хөгжлийн төвийн захирал Квази Премпек "Хятадууд Африкийн улс төрийн дээдэстэй дотноддог ч ард түмэнд нь тэгж ханддаггүй. Африкийн элитүүд тэдэнтэй бизнес хийдэг ч ил тод байдал үзэгддэггүй. Хүн амын түвшинд хятадууд өрнөдийнх шиг зөвхөн хүчний бодлогыг хэрэгжүүлэх чадваргүй" хэмээн өгүүлсэн юм.



Бээжин АНУ-ын хэлэлцээ хийх саналыг хүлээн авсангүй

Том Митчелл
Худалдааны асуудлыг хэлэлцэх АНУ-ын саналаас Бээжин татгалзаж, Хятадын офицерт хориг тавьсан асуудалд Бээжин дэх зэвсэг Элчин сайд сануулга өгсөн нь хоёр улсын харилцааг нэлээд хурцатгалаа. АНУ, Хятадын ардын чөлөөлөх армийн зэвсэг боловсруулах нэгтгэл болон тус ангийн дарга дэслэгч генерал Ли Шанфуд хориг арга хэмжээ авахаа мэдэгдсэн. Үүний дараа Хятадын Гадаад хэргийн яамны АНУ-ыг хариуцсан орлогч сайд Жэн Зегуан Элчин сайд Терри Брандстадыг дуудан ярилцжээ.

Өнгөрсөн пүрэв гарагт АНУ, Хятадыг Оросоос байлдааны тийрэлтэт онгоц, пуужин худалдан авсны учир ХАЧА-ийн нэгтгэлд хориг арга хэмжээ авч буйгаа мэдэгдсэн. Энэ нь "Украин дахь

түрэмгийлэл, Крымийг эрхэндээ авсан, цахим халдлага, 2016 оны Америкийн Ерөнхийлөгчийн сонгуульд хөндлөнгөөс оролцсон болон бусад хорт явуулга"-ын улмаас Москвагийн зэвсгийн экспортод тавьсан хоригийг зөрчсөн гэх үндэслэлтэй юм. Ноён Жэн Элчин сайд Брандстадтай уулзах үедээ "Хятад, Оросын цэргийн хамтын ажиллагаа бол бие даасан хоёр улсын хэвийн харилцаа бөгөөд АНУ-ын зүгээс үүнд оролцох эрхгүй" гэжээ.

Тэрбээр "АНУ-ын алхам Бээжин, Вашингтоны харилцаа болон цэргийн хамтын ажиллагаанд ноцтой хохирол учруулна. Хятад улс АНУ-д хандаж нэн даруй алдаагаа засаж, хоригоо цуцлахыг хатуу сануулж байна" хэмээн мэдэгдэв. Хятадын Баглан хамгаалахын яам түүнчлэн "Олон улсын харилцааны

суурь журмыг бүдүүлгээр зөрчсөн хоригийг шийдвэртэй эсэргүүцэн зөвүүцж" буйгаа илэрхийлэв. БХЯ энэ сарын 25-нд болох хоёр талын цэргийн хэлэлцээг хойшлуулж, Тэнгисийн хүчний командлагч дэд адмирал Шен Жинлоны АНУ-д хийх айлчлалыг цуцалснаа мэдэгджээ.

Ийм маргаан АНУ-ын зүгээс Хятадын импортын бараг талд нь тариф ногдуулах Трампын шийдвэртэй зэрэгцсэн байна. Даваа

гарагаас хэрэгжиж эхэлсэн АНУ-ын тарифын хариуд Бээжин АНУ-аас ирэх 60 тэрбум ам.долларын импортод тариф тогтоох арга хэмжээ авсан. Ерөнхийлөгч Хятадын талаас адил арга хэмжээ авбал Хятадаас ирэх нийт импортод тариф тогтооно хэмээн мэдэгдээд буй.

Хятадын Худалдааны дэд сайд Ван Шоувэн өнгөрсөн долоо хоногт Вашингтонд ирэх байсан боловч хойшлуулсан. Тарифын улмаас уг айлчлал болох эсэх нь тодорхойгүй байна гэж байдлыг мэдэх хүмүүс ярилаа. АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Майк Помпео Fox телевизэд өгсөн ярилцлагадаа "Хятадын талаас АНУ-ын эсрэг олон жилийн турш худалдааны дайн хийж байгаа. Үүнийг дайн гэж хэлэх түвшинд хүрсэн. Бид ялах шийдвэр төгс байна" хэмээн мэдэгдсэн байна.



Bird-ийн скутерийн үйлчилгээ дэлхийд жигүүрээ дэлгэх нь

Тим Брэдшоу

Скутер түрээсэлдэг Bird стартап тэлэлтийн шинэ шатандаа Ази, Латин Америкийн зах зээл рүү өргөжиж байна. Цаашид орон нутгийн өрсөлдөгч бий болохоос урьтахыг зорьж байгаа юм. Эднийх Мумбай, Бангкок, Сингапур, Сөүл, Ханой зэрэг Азийн хотууд, Мехико, Богота, Лиам, Буэнос Айрес гэх мэт Латин Америкийн хотуудад менежер болон логистикийн ажилтан хөлсөлж эхэлжээ. Энэ сард онлайн тавьсан ажлын зараас үзэхэд Хонконгд оффисоо байгуулсан Хятадад Mobike, Ofo зэрэг дугуй түрээслэгчидтэй өрсөлдөхөөр зэхэж буй бололтой. Bird-ийн хэвлэлийн төлөөлөгч ажлын зарын талаар тайлбар өгсөнгүй.

Лос Анжелест төвтэй Bird компани АНУ-аас гадагш тэлэхэд зориулж, зургадугаар сард 300 сая ам.доллар босгосон. Улмаар цахилгаан скутерээ Парис, Брюссель, Вена, Тел Авивт хүргэжээ. Эдний гол өрсөлдөгч Lime бас гадаадад гарах алхмаа Европоос эхэлсний зэрэгцээ оны эцэс гэхэд 150 зах зээлийг хамрахаар төлөвлөсөн байна. Үүнээс гадна Uber компани цахилгаан дугуйны Jump үйлчилгээг олон улсад нэвтрүүлэх бодолтой байгаа.

Түүнчлэн эдний скутер



хуваалцах үйлчилгээг экспортод гаргах боломжтой.

Өрсөлдөөн ширүүсэхийн хамт Bird, Lime хоёр өнгөрсөн онд хэдэн зуун сая ам.доллар босгож, салбартаа тэргүүлэхийг эрмэлзэж байна. Тэд АНУ-ын хотуудад тургэн өргөжиж, хэдэн сая хэрэглэгчдийг татсанаар одоо 20 сая удаа үйлчилгээ үзүүлжээ. Шинэ үйлчилгээг тойрсон зохицуулалт ба аюулгүй байдлын асуудлыг үл харгалзан тэд урагшилсаар байна. Энэхүү өсөлтийг дэлхийн бусад хэсэг дэх хөрөнгө оруулагчид болон бизнесменүүд саяхныг хүртэл ажиглаагүй аж.

Жишээ нь, наймдугаар сард байгуулагдсан Бразилын анхны дугуй, скутер хуваалцах Yellow үйлчилгээ Цахиурын хөндийн

хөрөнгө оруулагчдаас 75 сая ам.доллар татжээ. Эднийх саяхан шинээр санхүүжилт авах үедээ Бразилаас гадна Мексик, Колумб, Чили, Аргентин руу өргөжихөөр төлөвлөж буйгаа зарласан. Yellow өөрийн скутер үйлдвэрлэх чадамгай болгохоос ажиллаж буй. Хятадын Mobike үйлчилгээ гадаад зах зээлд гарахыг оролдсон боловч эвдэн сүйтгэх эсэргүүцэлтэй тулгарсан тул ухрахад хүрсэн байна.

Үүний дараахан Ази руу нэвтрэхээр төлөвлөсөн Bird ажлын зар өгөхийн сацуу өөрөө скутерийн дизайн, үйлдвэрлэл хөгжүүлэх бодлоо илэрхийлэв. Дэлхийн нийт скутерийн ихэнхийг Хятадын Segway-Ninebot компанид үйлдвэрлэдэг бөгөөд аль нэг орны хэрэглэгчдэд тохируулах боломж хомс. Bird-ийнхэн саяхнаас Хятадын Elecs-tisan компанид үйлдвэрлэсэн илүү бат бөх скутерийг туршиж эхлэв. Унааны энэхүү хэрэгсэл хуваалцахын тулд үргэлж гудамжинд үлдээж, хэд хэдэн хүн ээлжлэн хэрэглэхүйц чанартай, аюулгүй байдлыг хангахуйц дизайнтай байх ёстой. Тус стартап түүнчлэн үйлдвэрлэлийн хянах инженерүүд болон судалгаа, хөгжүүлэлтийн ажилтнууд хөлслөх зар гаргасан байна.



Жим Пикард

Хөдөлмөрийн намаас дэвшүүлсэн төлөвлөгөөгөөр Британийн том компаниуд үнэт цаасныхаа 10 хувийг ирэх арван жилд багтаан ажилчдаа шилжүүлэх ёстой болж байна. Уг төлөвлөгөөг нэгдсэн вант улсын бизнесийн групп “өршөөлгүй хахир” хэмээн тодорхойлов.

Их Британийн бизнесийн түүхнээ хамгийн интервенционист бодлогын нэгийг сүүдрийн сангийн сайд Жон МакДоннел танилцуулсан юм. Сүүдрийн сайдынхаар ажилчид ажил олгогчдынхоо “тодорхой хэсгийг эзэмшигч” байж жилдээ 500 фунт стерлинг хүртэл ноогдол ашиг хүртэнэ.

Шинэ бодлогын дүнд олон жил царцанги байсан цалин өөрчлөгдөж сая сая ажилчин халаасандаа мөнгөтэй болно хэмээн Хөдөлмөрийн нам үзжээ.

Компанийн татварыг өсгөх, нийтийн үйлчилгээний компаниудыг улсад шилжүүлэх, ажилчдад хөдөлмөрлөх бүрэн эрх олгох зэрэг заалттай уг бодлого нь Хөдөлмөрийн намын зүгээс хүлээн зөвшөөрөх аргагүй халдан довтолж буй үйлдэл хэмээн бизнесийн группүүд үзлээ.

“Ажиллагсад хувь эзэмшүүлэх албадлага нь хөрөнгө оруулагчдыг хохироож дайжихад хүргэнэ. Хөрөнгө оруулалт багасвал бүтээмж, цалин ч буурна” хэмээн СВИ-ийн захирал Кэролайн Файрберн тайлбарлав.

Хөдөлмөрийн намын бодлого нь Их Британийн нийт эдийн засагт хохиролтойг Захирлуудын Хүрээлэнгийн (Institute of Directors) тэргүүн Стивен Мартин анхаарууллаа.

“Эзэмшлийнхээ 10 хувийг хувьцаа эзэмшигчдээ ажилтнуудаа шилжүүлэхээр компаниудыг албадах нь хахир хатуу гэхэд ч зөөлдөнө. Бизнесийн хөрөнгө оруулалт, Их Британийн



Ажилчид ажил олгогчдынхоо “тодорхой хэсгийг эзэмшигч” байх ёстой хэмээн Их Британийн сүүдрийн сангийн сайд Жон МакДоннел мэдэгдэж байна.

ажилчид дотроос сонгосон “Итгэмлэгчдийн Зөвлөл” удирдан хөтлөх юм. Бусдад худалдах, шилжүүлэх эрхгүй ногдол хувьцааг нэгдсэн вант улсын ажилчид хувь эзэмшдэг компаниудад үйлчилж буй “актив түгжих” тогтолцооны дагуу эзэмших эрхтэй.

Хөрөнгийн зах зээлд ийм санал санаачилгаас айж эмээх хэрэг гарахгүй хэмээн сүүдрийн сайдын шадар туслах тайвшруулж байна. “Жилдээ нэг хувь гэдэг бол хариугүй бага хэмжээ” хэмээн туслах үзэж байлаа.

Гэтэл Сангийн яамны ерөнхий нарийн бичийн дарга Лиз Трасс уг бодлого нь компаниудыг ажилтан, ажилчдаасаа хөндийрөхөд хүргэнэ хэмээн анхааруулав. Тэгээд ч консерватив намынхны засгийн газар ажилчдын хувь эзэмшлийг өсгөх арга хэмжээ хэдийн авчихсан хэмээн хатагтай Трасс мэдэгдсэн юм.

Компанийн засаглалаа сайжруулах шаардлагатай Их Британийн ажилтан, ажилчдад

Их Британийн компаниуд хувьцаанаасаа ажилчдадаа эзэмшүүлж магадгүй байна

бизнесийн орчинд сөрөг нөлөөлж нэгдсэн вант улсын хөрөнгийн зах зээлийг бусниулна” хэмээн тэрбээр өгүүлэв.

Уг бодлогын дагуу Их Британийн 250-иас дээш тооны ажилтан бүхий бүх компани “дотоодын эзэмшлийн сан” байгуулах үүрэг хүлээнэ.

Компаниуд жил бүр эзэмшлээсээ дор хаяж нэг хувийг тус санд шилжүүлэх замаар 10 хувьд

хүргэх юм. Шинэ бодлого хэрэгжиж эхэлснээс хойш таван жилийн дараа тус улсын ажилчид жил бүр дөрвөн тэрбум фунт стерлингийн ногдол ашиг хүртдэг болно хэмээн Хөдөлмөрийн нам тооцоолжээ.

Энэхүү хувь хэсгийг “хамтран” эзэмшиж зохицуулах ажилчид компанийн ирээдүйтэй холбоотой шийдвэр гаргах эрхийг бусад хувьцаа эзэмшигчдийн

адилаар эдэлж, ногдол ашгаа хүртэж явах болно.

Нэг ажилтан ажилчинд ногдох ашиг жилдээ дээд тал нь 500 фунт стерлинг. Илүү гарсан нь нийтийн санд хуримтлал болно. Ийм бодлого нэгдсэн вант улсын том корпорациудад ажилладаг 10.7 сая ажилтан, ажилчинд өгөөжтэй хэмээн сүүдрийн сайд үзлээ. Мөн жижиг компаниуд сайн дурын үндсэн

дээр “дотоодын эзэмшлийн сан” байгуулж болно.

Гэхдээ амьдрал дээр ногдол ашиг тогтмол төлөөд байдаггүй хувийн компаниудад уг бодлого хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй. Их Британид салбартай гадаадын компаниудад уг журам үйлчлэхгүй.

Төслийн түвшинд байгаа шинэ бодлогоор, “дотоодын эзэмшлийн сан”-г компанийн

арван хувийн эзэмшил хуваарилах санаачилгыг зөв зүйтэй алхам хэмээн нэгдсэн вант улсын үйлдвэрчний эвлэлүүдийн төв байгууллага – Трейд Юнион Конгрессын төлөөлөгч өгүүлэв. “Ажилчид компаниуддаа ахиу хувь эзэмшиж, эрхлэн удирдах ажилд илүү чөлөөтэй дуугардаг болох ёстой” хэмээн төлөөлөгч тайлбарлаж байлаа.



Barrick, Randgold хоёр \$18 тэрбумаар нэгдэнэ

Хэнри Сандерсон, Нил Хьюм

Канадын Barrick Gold компани Лондонд бүртгэлтэй өрсөлдөгч Randgold Resources-ыг өөртөө нэгтгэх яриа хэлэлцээ өрнүүлж байна. Нийт 18 тэрбум ам.доллараар хэмжигдэж буй бизнес хэлцэл амжилттай өндөрлөх аваас дэлхийд тэргүүлэх алт үйлдвэрлэгч шинээр үүсэх юм.

Алт олборлолт, үйлдвэрлэлийн салбарт бүтэн жил үргэлжилж буй дүнсгэр яриа хэлэлцээ хөрөнгө оруулагчдын сонирхлыг төдийлэн татаж чадахгүй өдий хүрлээ.

Баримталж буй стратеги нь шүүмжлэлд өртсөнөөс Barrick-ын хувьцаа 25 хувиар, гол уурхайнх нь нэгэнд ажил хаялт зарласан зэрэг хэд хэдэн хүнд нөхцөлтэй тулгараад буй Randgold-ынх 34 хувиар унажээ. Энэ нь чанга ханштай ам.доллараас

болж нэг унцных нь үнэ жилийн өмнөх үеэс ес гаруй хувиар буусан алтныхаас ч ноцтой уналт юм.

Randgold, Barrick хоёрын яриа хэлэлцээг анх мэдээлсэн уул уурхайн IKN блог сайт хоёр компанийн нэгдэх шийдвэр ням гарагт эсвэл арилжаа эхлэх даваа гарагт гарна хэмээн таамаглаж байлаа. Яриа хэлэлцээ шинэ шатанд үргэлжилж байгааг дараахан нь Bloomberg мэдээлэв.

Тайлбар хөгсөн хүсэлтэд Barrick хариу өгөөгүй бол Randgold татгалзлаа.

Barrick-ыг урьд нь Goldman Sachs-д банкир байсан Жон Торнтон тэргүүлж байгаа. Тэрбээр 2014 онд гүйцэтгэх захирал болсноосоо хойш Торнтонд төвтэй группийн олборлолтыг өргөжүүлэхээ илүүтэй бэлэн мөнгөний урсгалыг тэнцвэр-

жүүлэх, ашиггүй хөрөнгийг зарахад анхаарч ажилласан юм.

Дүнд нь компанийн олборлолт буурч, дэлхийн алтны тэргүүлэх олборлогч гэсэн алдраа Канадын өрсөлдөгч Newmont Resources-т алдах аюул нүүрлэв. Аюулаас мултрах нэг арга нь Өмнөд Африк гаралтай хэрүүлч эр Марк Бристоу тэргүүлж буй, дэлхийд шилдэг үнэлгээтэй алт олборлогчийн нэг Randgold-ыг худалдаж авах явдал.

Randgold-ыг бахархан шагшиж буй ноён Торнтон тус компанийн “супер орлого”-оос үлгэр жишээ авах хүсэлтэйгээ Канадын Globe and Mail сонинд саяхан тайлбарласан. Үнэт цаасны зах зээлд 12 тэрбум ам.долларын үнэлгээтэй Barrick нь Randgold-оос хоёр дахин үнэтэй компани.

Randgold-ыг нэгтгэсэнээр



Barrick компанид с ү л и й н хоёр жил бүртэл муутай өнгөрсөн Африк дахь бизнес нь сайжрах боломж бүрдэнэ.

Хувьцааных нь ихэнхийг эзэмшдэг Акасия уурхайн олборлолтын асуудлаар Barrick компани Танзанийн ерөнхийлөгчтэй яриа хэлэлцээ

өрнүүлж байна. Barrick нь 2017 оны дөрөвдүгээр сараас хойш тус улсаас таваар экспортлох аргагүйд хүрсэн юм.

Ноён Бристоу 1995 онд үндэслэн байгуулсан Randgold нь д э л х и й н хамгийн н э р

хүндтэй алтны компанийн нэг. Тус компани Африкийн уул уурхайн бизнест хамгийн халгаатай орнуудад амжилттай

ажиллаж чаддагаараа алдартай.

Randgold компани Мали, Кот-д'Ивуар, засгийн газар нь саяхан уул уурхайн таагүй зохицуулалт үүсгэсэн Конгийн Ардчилсан Бүгд Найрамдах Улсад нийт таван уурхай ажиллуулж байна. Тус компани энэ жил 1.3 саяас 1.35 сая унц алт олборлохоор төлөвлөжээ.

Энэ оны турш ам.долларын ханш чангарсан нь алтны үнэд нөлөөлж, гадаадын худалдан авагчдад үнэтэй таваар болж хувирлаа.

АНУ-ын бодлогын хүү нэгдүгээс сараас хойш тогтвортой өсөж, Сангийн яамны гурван сарын хугацаат үнэт цаасны өгөөж 2.15 орчим хувьтай болсон. Үүнтэй уялдан алт хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах нь багассаар байна.



Хонконг Хятадын суман галт тэрэгний сүлжээнд холбогдлоо



BVM©

Бэн Бланд

Хугацааг нь олон жил сунгаж, зардал хэтэрсээр 11 тэрбум ам.долларт хүрсний эцэст Хонконгийн Хятадын өндөр хурдны төмөр замын аварга сүлжээтэй сая нэг холбов. Хагас

автономит нутаг дэвсгэрийг улс орны бусад хэсэгтэй холбох Бээжингийн агуу хүчин чармайлт ийнхүү өндөрлөж байна.

Хонконгийн дэлхийн өндөр хурдны галт тэрэгний хамгийн

аварга сүлжээтэй холбож буй 26 километр шугам нь уг дэд бүтцийг дэмжигч, гүтгэн гүжирдэгч нарын аль алинд утга учиртай. Дэмжигчид уг шугамыг эдийн засгийн хүч чадлын бэлгэ тэмдэг, эх газрын

Хятадтай нийгмийн хувьд нэгдэн нийлэх явцыг хурдасгагч хэмээн үзэж байна. Гүтгэн гүжирдэгч нар уг шугамыг Хонконгийн тусгаар бие даасан байдал устах явцыг хурдасгагч гэж бүтэц хэмээн өөлж байгаа юм.

“Хонконгийн хувьд түүхэн мөч. Өндөр хурдны төмөр замын сүлжээнд нэгдсэн нь бүс нутгийн интеграцид чухал түлхэц өгнө” хэмээн эх газрын Хятадын засгийн газраас томилсон Хонконгийн тэргүүн Кэрри Лам үнэлэв.

Хонконгийн төв дэх өчнөөн нүх сүв болсон Вест Каулун өртөөнөөс хөдлөх зорчигчид эдүгээ Бээжинд хуучин шигээ 24 биш есхөн цагийн дотор хүрдэг боллоо. Бүтэн цаг давхиж очдог байсан зэргэлдээх Шэньжэнд цагт 300 гаруй километр хурдтай суман галт тэрэгний ачаар 15 минутын дотор хүрнэ.

Харин Хонконг дахь

ардчиллын төлөө тэмцэгч нар тус хотын галт тэрэгний өртөөний зарим хэсгийг эх газрын Хятадын нутаг дэвсгэр болгож, хятад цагдаа, хилийн харуул ажиллуулж буй Бээжингийн шийдвэрийг эсэргүүцэх кампани өрнүүлж байна.

“Суурь хууль зөрчиж, Хонконгийн автономит эрхэнд халдсан хэрэг” хэмээн сөрөг хүчний хууль тогтоогч Таян Чан шүүмжлэв. Суурь хууль нэртэй бяцхан Үндсэн хууль нь Хонконгийн хууль зүй, иргэний эрх, “онцгой дээд автономит эрх”-ийг 1997 онд Их Британи колонио шилжүүлж өгснөөс хойших 50 жилийн турш хамгаалах баталгаа болдог.

Энэхүү зөрчил ням гарагт суман галт тэрэгний шинэ үйлчилгээнд дугаарлаж байсан үй олон зорчигчид хамаагүй боллоотой. Өндөр хурдны төмөр зам Азийн санхүүгийн төвийг эх

газрын Хятадын 44 хоттой шууд холбож байна. Эдгээр хотын ихэнх нь Хонконгтой агаарын тээврийн шууд нислэггүй.

“Хятадын өндөр хурдны суман галт тэрэг асар хурдацтай хөгжиж байна. Ер нь дэлхийд шилдэг нь байх аа” хэмээн Бээжин хүрэх нэг талын тасалбарт 160 ам.доллар төлсөн өндөр настан Хуй Чуньпин үнэллээ.

Улс төрийн зорилгыг нь үл тооцох аваас өндөр хурдны галт тэрэгний төсөл зардлаа нохож чадах эсэхэд шинжээч нар эргэлзсээр. Хятад орны өндөр хурдны галт тэрэгний сүлжээнд Бээжин-Шанхай зэрэг цөөн хэдэн шугам л ашигтай ажилладаг. Хонконгийн эх газрын Хятадтай холбосон 26 километр шугам бүхэлдээ газар дор оршдог бөгөөд километр тутам нь 420 сая ам.долларын өртгөөр бүтжээ.



Эдийн засаг

БАНК САНХҮҮ

Зээлийн хүү оны эхнээс 0.5-2.2 хувиар буурчээ

1999 онд 45 хувьд хүрч байсан зээлийн хүү буурсаар 20 хувиас доошлоод байна



Б.Батдорж / ЗГМ ©

Төв банкны шинжээчид зээлийн хүүг өдөөж буй хүчин зүйлсийг судалсан. Гэтэл манай улсад санхүүгийн зуучлалын үйлчилгээ харьцангуй хямд ч хууль эрхзүй, макро эдийн засаг, инфляц зэрэг хүчин зүйлийн нөлөө өндөр гэсэн дүн гарчээ. Мөн зээлийн эх үүсвэр болох хадгаламжийн хүү өндөр байгаа нь ч санхүүгийн бүтээгдэхүүний өртөг өсөхөд нөлөөлж буйг Монголбанкны судлаачид онцолж байна. Тодруулбал, бодит зээлийн хүүгийн 71.7 хувь бодит хадгаламжийн хүүгээс шууд хамаардаг аж. Харин 27.9 хувь нь зээл болон хадгаламжийн хүүгийн зөрүү буюу бусад хүчин зүйлсээс хамааралтай.



1999 оны үед манай улсад зээлийн хүү 45 хувьтай байжээ. Одоогийн Бразил улсын банкны хүүтэй ойролцоо энэ хүү сүүлийн 20 орчим жил тасралтгүй уруудаж байгаа аж. Ингэхдээ

гурав гурван жилийн давтамжтай буурсаар 20 хувиас доошлоод байгаа. Ялангуяа, 2000-2011 онд тогтвортой буурч байсан ч 2012 оноос макро эдийн засгийн орчин суларснаас үүдэн сүүлийн 7-8 жил зээлийн хүүгийн бууралт удааширчээ.

Зээлийн хүү нь эдийн засгийн "халууны шил", эрсдэлийн толь болдог. Тиймээс зах зээлийн зарчмаар тогтсон энэ "халууны шил"-ийг хүчээр бууруулах нь зохистой. Гэхдээ зөв эмчилгээ чухал. Хүү өндөр байгаагийн бурууг аль нэг байгууллагаас хайж, арилжааны хэдэн банкаа

чичлэх нь эзнээ олоогүй үйлдэл хэмээн Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал С.Дэмбэрэл хэлж байна.

Тиймээс ул суурьтай авч үзэхээр Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс "Зээлийн хүүг бууруулах стратеги" баталсан юм. Мөн энэ чиглэлийн хэлэлцүүлгүүдийг ч зохион байгуулж байна. Төв банкнаас зохион байгуулсан зээлийн хүүгийн хэлэлцүүлэгт Монголын банкны холбоо, арилжааны банкууд, эрдэмтэн судлаачид, эдийн засагчид оролцлоо. [ЗГМ]



УИХ-ын гишүүн
Б.Жавхлан

Өнөөдөр зээлийн дундаж хүү 18 хувьтай байна. Гэтэл инфляцын түвшин 8-9 хувьтай. Инфляцын түвшнийг арилжааны банкууд эсвэл хэрэглэгчид бий болгоогүй. Энэ бол цэвэр макро бодлого, төсвийн бодлогын тусгал. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд бий болгосон санхүүгийн дүр төрх. Гэхдээ зээлийн хүү огт бууралгүй, таг гагцхиагүй. Тодорхой хувиар буурч байгаа. Цаашид ч аажмаар буурах төлөвтэй байна. Зээлийн хүүг бууруулах гол хүчин зүйл нь макро тэнцвэр юм.



Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал
С.Дэмбэрэл

Зээлийн хүүг бууруулах гол хүчин зүйл нь макро тэнцвэр. Зээлийн хүү бол зөвхөн мөнгөний бодлогын асуудал биш, макро эдийн засаг, түүний дотор төсвийн бодлоготой ч холбогдоно. Мөн микро түвшинд буюу арилжааны банкууд, банк бус санхүүгийн байгууллагуудын санаачилга чухал. Нөгөө талаас зээлийн хүү бол түүнийг олгож буй болон авч байгаа талуудын авир төрхийн асуудал. Тиймээс хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх ажлыг мартаж болохгүй.



Худалдаа хөгжлийн банкны ерөнхийлөгч
Б.Мэдрээ

Зээлийн хүү нь айл өрх бүрт хамаатай. Үүнийг бууруулахын тулд улс орон даяар анхаарлаа хандуулах хэрэгтэй. Зээлийн хүү өндөр байгаад хэн нэгнийг буруутгахаас илүү яагаад энэ түвшинд хүрсэн учир шалтгааныг судлах хэрэгтэй. Үүнийг парламентаас зохион байгуулж, гардан хариуцаад, Монголбанк, арилжааны банкууд, Сангийн яам, тэргүүлэх эрдэмтэн судлаачид, шилдэг эдийн засагчидтай хамтран судалгаа хийж, учир шалтгааныг олох нь чухал. Үүнд маш ажил хэрэгчээр хандах хэрэгтэй. Зээлийн хүүг бууруулах бүрэн боломж бий. Гагцхүү хамтран ажиллах нь чухал байна.



"Хас" банкны гүйцэтгэх захирал
М.Болд

Зээлийн хүүд хүчээр хязгаар тогтоох нь том сөрөг үр дагавартай. Зээлийн хүүг тогтоосноор чөлөөтэй урсаж байх учиртай хөрөнгийн урсгалд хязгаарлалт тавина гэсэн үг. Ингэснээр хадгаламжийн хүү хүчээр буурч эхэлнэ. Улмаар хадгаламж буюу зээлийн эх үүсвэр сүүдрийн эдийн засгийг чиглэнэ. Тухайлбал, иргэд мөнгөө ам.доллар луу хөрвүүлж эхэлнэ. Энэ хэрээр монгол төгрөгийн ханш суларна. Мөн хөрөнгөө үл хөдлөх хөрөнгө рүү оруулахаар орон сууц, үл хөдлөх хөрөнгийн үнэ өснө. Эргээд инфляц хөөрөгднө. Бичил бизнесийн зээл хумигдаж, ядуурал улам тэлнэ.



Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны ерөнхийлөгч
А.Алтансүх

ББСБ-ын жилийн дундаж хүү 36 хувьтай байна. Зээлийн хүүг бууруулахын тулд эрсдэлийг багасгах нь зүйтэй. Үүний тулд үйл ажиллагааны зардлыг бууруулах ёстой. ББСБ-ын санхүүжилт татах боломж хомс байдаг. Гадаад зах зээлээс татлаа гэхэд манай улсын зээлжих зэрэглэл сайнгүй. Энэ төрлийн санхүүжилтээс давхар татвар авдаг гээд хүндрэлүүд тулгарч байна. ББСБ-ын үйл ажиллагааны зардал өндөр байгаа. Тиймээс финтек технологи ашиглан үйл ажиллагаа явуулахаар зорьж байна. Энэ хэрээр үйл ажиллагааны зардал буурна гэж үзэж байна.

ТҮҮХИЙ ЭД

Түлшний компаниудад таатай үе тохиож байна



ОХУ-ын газрын тос, байгалийн хийн компаниудад бизнес хамгийн таатай үе тохиож байна. Учир нь эдгээр компанийн арилжааны индекс энэ сард рублийн дүнгээр бүх цаг үеийн дээд цэгт хүрч, ам.долларын дүнгээр 2014 оны зургаадугаар сараас хойших хамгийн өндөр түвшинд хэлбэлзэж байна. Рублийн ханш суларсан тул ам.доллараар нэрлэсэн газрын тосны үнэ өсөж, ОХУ-ын газрын тос олборлогчдын ашиг

нэмэгдэж байгаа аж. Мөн өр зээлийн хэмжээ нь буурч буйг шинжээчид онцоллоо. Гэхдээ АНУ ОХУ-ын эсрэг хоригоо чангатгаж болзошгүй байгаа нь зарим эрсдэл дагуулж буйг шинжээчид анхааруулж байгаа юм. ОХУ энэ онд Их Британид химийн зэвсэг ашиглаж, халдлага үйлдсэн хэрэгтэй холбоотойгоор АНУ ОХУ-ын эсрэг хориг тавьсан төдийгүй тус улсыг сонгуульд хөндлөнгөөс нөлөөлсөн, эсэхийг шалгаж байгаа юм. [ЗГМ]

ХАНШ

Хөгжиж буй орнуудын валютын ханш унаж байна

АНУ-ын төв банк бодлогын хүүгээ 2018 он гарснаас хойш хоёр удаа өсгөсөн. Энэ долоо хоногт дахин өсгөх магадлал өндөр байгааг шинжээчид онцолж байна. БНХАУ болон АНУ-ын худалдааны маргаан хурцарч болсноор хоёр улс импортын бараа бүтээгдэхүүний тарифаа нэмэгдүүлэх шийдвэрт хүрсэн. Үүнтэй зэрэгцэн Олон улсын валютын захад ам.долларын

ханш сүүлийн хагас жилд голлох зургаан валютын эсрэг 5.3 хувиар өссөн.

Харин ам.долларын ханш олон улсад чангарснаар Ази төдийгүй хөгжиж буй орнуудын валютын ханш огцом унаж байна. Тухайлбал, Аргентины бараа бүтээгдэхүүний тарифаа ам.долларын эсрэг 40-50 хувиар унаж, энэ он гарсаар үнэ цэнээ хоёр дахин алджээ. Мөн

Индонезийн рупиагийн ханш унаж сүүлийн хорин жилийн доод түвшинд хүрээд байна. Дэлхийн 146 улсын валютаас 100 орчим улсын ханш ам.долларын эсрэг унаад байна. Үүнд монгол төгрөг ч багтаад буй. Өөрөөр хэлбэл, төгрөгийн ханш ам.долларын эсрэг 3.8 хувиар унаад байна. Даваа гарагийн байдлаар ам.долларын албан ханш 2520 төгрөг давсан. [ЗГМ]

САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

"Материалимпекс" ББСБ байгуулна

"Материалимпекс" компани шинээр Банк бус санхүүгийн байгууллага байгуулахаар төлөвлөж байна. Тиймээс тус компани ирэх сарын 2-нд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаа хийхээр болжээ. Тус компани шинэ санхүүгийн

нэгжээ 100 хувь эзэмшиж, охин компани хэлбэрээр үйл ажиллагааг нь явуулах аж. Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг багадаа 2.5 тэрбум төгрөг байхаар

тогтоосон. Тэгвэл уг хөрөнгийг хэрхэн гаргах нь одоогоор тодорхойгүй байна.

"Материалимпекс" компани 2018 оны эхний хагас жилд 9.23 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 361.5 сая төгрөгийн алдагдал хүлээсэн юм. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» АШИГТ МАЛТМАЛ

0.7

Хувь. Зэсийн ханш 0.7 хувиар буурч, 6316.5 ам.доллар болжээ.

» ХАНШ

Японы иений ханш ам.долларын эсрэг 112.5 болж буурчээ.

0.4

Хувь. Алтны ханш 0.4 хувиар буурч, 1195.4 ам.доллар болжээ.

» БОНД

2.7

Хувь. Австралийн 10 жилийн хугацаатай бондын өгөөж 2.7 хувьтай байна.

» ГАЗРЫН ТОС

72

Ам.доллар. WPI төрлийн газрын тосны үнэ 1.8 хувиар өсөж, баррель нь 72 ам.долларт хүрчээ.

» АРИЛЖАА

208.2

Сая төгрөг. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар хоёр бирж нийт 24 хувьцаат компанийн 417.6 мянган ширхэг хувьцаа арилжаалагдаж, 208.2 сая төгрөгийн гүйлгээ хийлээ.

» ҮНЭТ ЦААС

174.6

Сая төгрөг. Монголын хөрөнгийн биржийн I ангилалд найман компанийн 90 мянган ширхэг хувьцаа 174.6 сая төгрөгөөр арилжв. Харин II ангилалд 14 компанийн 326 мянган ширхэг хувьцаа 33.4 сая төгрөгөөр, III ангилалд нэг компанийн 101 ширхэг хувьцаа 62.5 мянган төгрөгөөр тус тус арилжжээ.

» ХӨРӨНГИЙН БИРЖ

1.6

Тэрбум төгрөг. Монголын хөрөнгийн бирж энэ оны есдүгээр сарын 17-21-ний өдрүүдэд үнэт цаасны таван удаагийн арилжаа зохион байгуулж, өдөрт дунджаар 1.6 тэрбум төгрөг буюу нийт 8.2 их наяд төгрөгийн арилжаа хийсэн байна.

» ТАВААР

401.3

Тэрбум. БНСУ-ын POSCO групп Монгол Улсын литийн нөөцийг сонирхож байна. Өнгөрсөн оны байдлаар POSCO Daewoo компанийн үйл ажиллагааны орлого 401.3 тэрбум вонд хүрсэн бол борлуулалт нь 22.5 их наяд вонд хүрчээ.

ВАЛҮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,523.10
Евро	2,962.31
Японы иен	22.41
ОХУ-ын рубль	38.13
БНХАУ-ын юань	367.95
БНСУ-ын вон	2.25

Эдийн засаг

Хайгуулын зардлыг ангилж үзвэл ихээхэн сонирхолтой дүр зураг харагдана

П.Жамсран
Сэтгүүлч

Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт таван жил дараалан унаад байсан бол 2017 онд өмнөх оноос 61 хувиар өсчээ. Хувьцааны санхүүжилтийн хэмжээ ч ихээхэн нэмэгдсэн. Хөрөнгийн бирж дээр шинээр босгосон хөрөнгийн хэмжээ 18 тэрбум ам.доллар давлаа. Үүний 8.9 тэрбум нь өнгөт металлын компаниудад хамаарна. Үүнийг дагаад хайгуулын зардал ч мөн өссөн дүнтэй гарчээ. S&P Global market intelligence компанийн гурван мянган хайгуулын компанийг хамруулсан судалгаагаар өнгөрсөн онд өнгөт металлын хайгуулын зардал 2016 оноос нэг тэрбум ам.доллараар нэмэгдэж, 8.4 тэрбум ам.доллар болсон зэрэг 2017 он бүхэлдээ уул уурхайн салбарт ногоон гэрэл асаасан жил байв. Энэ жил ч нөхцөл байдал өнгөрсөн оноос илүү байна.

Олон Улсын Валютын Сан (ОУВС) өнгөрсөн онд дэлхийн эдийн засгийн өсөлт 3.7 хувь байсан бол энэ жил 3.9 хувиар өсөх хүлээлттэй байгааг мэдээлсэн. Түүхий эдийн шинжээчид дэлхийн эдийн засгийн өсөлтийг дагаад металлын зах зээл эерэг байна хэмээж байгаа. Дэлхийн банкны мэдээллээр суурь металлуудын үнийн индекс 2017 оны сүүл гэхэд жилийн дүнгээр 25 хувиар өсөлт үзүүлсэн бол ОУВС-гийн тооцоолсноор өнгөрсөн хоёр жилд суурь металлын сарын дундаж үнэ 36-110 хувиар өссөн бол үнэт металлын сарын дундаж үнэ 6-15 хувиар өсчээ. Металуудын үнийн өсөлтийн хувийг 2011 оны "БҮҮМ" үетэй харьцуулахад



Бүс нутгаар аваад үзвэл Канад болон Австрали нийт хайгуулын зардлын 25 хувийг бүрдүүлж байгаа бол АНУ болон Африк тив хамтдаа 20 хувь, Латин Америк 15 хувь, Зүүн өмнөд Ази болон Номхон далайн бүс нутаг 10 хувь, үлдсэнийг нь бусад бүс нутаг бүрдүүлж байгаа аж.

Asia Mining Magazine ©

Алт, зэсийн хайгуул эрчимжив

ашигт малтмалын зах зээлд бүхэлдээ эерэг өөрчлөлт авчирч байна. Дөрвөн жил дараалан унасан хайгуулын зардал өнгөрсөн онд өсөлт үзүүлсэн. S&P Global market intelligence компанийн тооцоолсноор өнгөрсөн оны өнгөт металлын хайгуулын зардал 8.4 тэрбум ам.доллар байв. Энэ нь хэдийгээр 2012 оны оргил үе буюу 20 тэрбум ам.доллар давж байсан үетэй харьцуулахад бага ч гэлээ 2016 оноос бараг тэрбум ам.доллараар давсан үзүүлэлт юм. Тэгвэл ирэх жил өнгөт металлын хайгуулын зардал 15-20 хувь өснө хэмээн тус байгууллага тооцоолжээ.

Хайгуулын зардлыг ангилж үзвэл ихээхэн сонирхолтой дүр зураг харагдана. Ашигт малтмалын бүхий л төрлийн хайгуулын зардал өссөн үү гэвэл үгүй. Үнэ нь

мөнгөний хэмжээ 1.6 тэрбум ам.доллар давсан байна. Энэ тоо ирэх жилүүдэд илүү их нэмэгдэх хүлээлттэй байгаа. Industrial Info Resource-н мэдээлсний дагуу дэлхийн дээр одоогоор бүтээн байгуулалт болон өргөтгөлийн шатандаа явж байгаа тэрбум ам.доллараас дээш хөрөнгө оруулалт шаардлагатай ТЭЗҮ бүхий зэсийн 31 төсөл байгаа аж. Харин нийт хайгуулын зардлын 6.8 хувийг цайрын хайгуул эзэлж байна. Дээр дурдсанчлан хамгийн их үнийн өсөлт үзүүлээд байгаа металл бол цайр. Наймдугаар сарын 16-ны байдлаар Лондоны металлын бирж дээр нэг тонн цайрын үнэ хоёр мянган ам.доллар байв.

Бүс нутгаар аваад үзвэл Канад болон Австрали нийт хайгуулын зардлын 25 хувийг бүрдүүлж

компаниудын төсөв 2016 оноос хоёр дахин өсөж, 157 сая ам.доллар болсон бол кобальтын хайгуулын 52 компанийн зардал 2017 онд 36 сая ам.доллар болж бараг дөрөв дахин өсчээ.

Харин Австрали улс өнгөрсөн онд 18 мянган тонн лити (метал-

хэмжигдэж байна. Тэгвэл Бүгд Найрамдах Ардчилсан Конго улс дэлхийн кобальтын хэрэглээний 60-аас илүү хувийг дангаараа олборлоод зогсохгүй нөөцийн хэмжээгээрээ дэлхийд тэргүүлэгч юм.

Хайгуулын зардал өссөн дүнтэй гарч буй нь нэг талаасаа

багадаа 10 метрээр нэмэгдсэн хэмээн үздэг. Тухайн үед шинэ нөөц илрүүлэхэд хамгийн гүн буюу дунджаар 204 метр өрөмдөж буй бүс нутаг нь АНУ байв. Харин Латин Америкийн орнуудад эрдсийн шинэ нөөц тогтооход дунджаар 32 метрийн гүн өрөмдөж байсан нь хамгийн багад тооцогддог. Цаашид илүү их нөөц нээж илрүүлэхийн тулд илүү гүн өрөмдөх шаардлагатай байгааг салбарын мэргэжилтнүүд онцлоосор буй. Энэ нь мэдээж хайгуулын зардал өсөх суурь шалтгаан юм.

ӨНГӨТ МЕТАЛЛЫН КОМПАНИУД 8.9 ТЭРБУМ ДОЛЛАР БОСГОВ

S&P Global market intelligence-н тооцоолсноор өнгөрсөн онд дэлхийн эрдэс түүхийн





Asia Mining

MAGAZINE

Asia Mining сэтгүүлийн захиалга үргэлжилж байна.

Утас: 99907829

цайрын өсөлт хамгийн их буюу тухайн үеийн үнийн түвшинээ 30 хувиар өндөр байгаа бол бусад металлынх долоон жилийн өмнөх ханшид хараахан очоогүй байна.

Өнгөрсөн оны тухайд дэлхийн эдийн засгийн өсөлт болон ам.долларын сулрал металлын үнийн өсөлтийн гол хүчин зүйл болсон хэмээн шинжээчид тайлбарлаж байна. Америкийн нэгдсэн улсын Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ бага түвшинд барьж, үүнтэй холбоотойгоор ам.доллар суларч эхэлсэн нь металлын үнийн өсөлтөд нөлөөлж буй нэг хүчин зүйл юм.

ГЕОЛОГИЧИД ӨНГӨТ МЕТАЛЛЫГ ИЛҮҮ СОНИРХОЖ БАЙНА


Түүхий эдүүдийн үнийн өсөлт

бусад металлаас дутахгүй өндөр өсөлт үзүүлсэн нүүрс, төмрийн хүдэр, уран гэх мэт түүхий эдийн хайгуулын зардал буурсан байхад алт, зэс болон цайрын хайгуулын зардал өссөн дүнтэй байна. Алтны хайгуул нийт зардлын 50-иас илүү хувийг дангаараа бүрдүүлсэн бөгөөд үүн дотор Канад болон Австрали улс хайгуулын зардлаар тэргүүлжээ. 2016 онд 19 хувиар буураад байсан Канадын алтны хайгуулын зардал 2017 онд бараг 50 хувиар нэмэгдэж, 750 сая ам.доллар болов. Мөн Австрали улс 200 гаруй сая ам.долларыг алтны хайгуулд зарцуулсан нь тус улсын нийт хатуу ашигт малтмалын хайгуулын зардлын 50-иас илүү хувийг бүрдүүлжээ.

Удаах металл нь зэс. 2017 онд зэсийн хайгуул зарцуулсан

байгаа бол АНУ болон Африк тив хамтдаа 20 хувь, Латин Америк 15 хувь, Зүүн өмнөд Ази болон Номхон далайн бүс нутаг 10 хувь, үлдсэнийг нь бусад бүс нутаг бүрдүүлж байгаа аж.

Батарейн түүхий эдийн үнийн өсөлт болон хайгуулын зардлын хэмжээг яах аргагүй онцлох нь зүйтэй. Учир нь өнгөрсөн оноос батарейн гол түүхий эд болсон лити, кобальтын эрэлт болон үнэ түүхэн дээд хэмжээ тогтоогоод буй. 99 хувийн агуулгатай лити карбонатын үнэ тонн тутамдаа 20 мянган ам.доллар давсан бол кобальтын үнэ тонн тутамдаа 90 мянган ам.доллар хүрсэн. Тэгвэл дээрх түүхий эдийн компаниудын хайгуулын төсөв ч нэлээд өссөн. S&P global market intelligence-н тооцоолсноор литийн хайгуулын



лаар) олборлож дэлхийн номер нэг олборлогч болсон бол дэлхийн нийт багтай тогтоогдсон литийн нөөцийн 50-иас илүү хувь нь бүртгэлтэй Чили улс 14 мянган тонныг олборлож удаалав. Дэлхийн хамгийн том литийн компани бол Чилийн SQM (Sociedad Quimica y Minera) бөгөөд зах зээлийн үнэлгээ нь 14 тэрбум ам.доллараар

суурь металлуудын болон шинэ эрдсүүдийн эрэлт нэмэгдэж буйтай холбоотой бол нөгөөтэйгүүр хайгуулын компаниуд шинэ ордыг нээж илрүүлэхэд илүү гүн өрөмдөх шаардлагатай байгаа юм. Minex-Consulting компанийн судалгаагаар хайгуулын компаниудын өрмийн дундаж нь 2013 онд 74 метр байсан бол өдгөө энэ тоо хамгийн

эдийн компаниудын хувьцааны санхүүжилтийн хэмжээ 29 тэрбум ам.доллар болж, 2016 оноос хоёр тэрбум ам.доллараар нэмэгджээ. Уг хэмжээ нь оргил үедээ буюу 2011 онд 53 тэрбум ам.доллар байсан бөгөөд тэр үеэс 2016 он хүртэл тасралтгүй унасан. Харин голлох хөрөнгийн биржүүд дээр шинээр босгосон хөрөнгийн хэмжээ 18 гаруй тэрбум ам.долларт хүрэв. Энэ нь 2016 оноос дөрвөн тэрбум ам.доллараар өссөн дүн аж. Харин өнгөт металлын хайгуулын компаниудын IPO хийж босгосон хөрөнгө 8.9 тэрбум ам.доллар болж сүүлийн таван жилийн дээд хэмжээнд хүрчээ. Торонтогийн бирж дээр хөрөнгө босгосон компанийн тоогоор бусад биржүүдийг тэргүүлсэн байна. **AsiaMining**

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:

<p>АПУ ХК</p> <p>Өдөр ↓ 0.73% Cap ↓ Жил ↑</p>	<p>ГОВЬ ХК</p> <p>Өдөр ↓ 0.19% Cap ↑ Жил ↑</p>	<p>ТАВАН ТОЛГОЙ ХК</p> <p>Өдөр ↑ 2.47% Cap ↑ Жил ↓</p>	<p>СҮҮ ХК</p> <p>Өдөр ↓ 0.75% Cap ↑ Жил ↑</p>
<p>Xanadu Mines Торонто</p> <p>Өдөр ↑ 12% Cap ↑ Жил ↓</p>	<p>Erdene Resource Development Лондон</p> <p>Өдөр ↑ 3.23% Cap ↑ Жил ↑</p>	<p>Aspire Mining Австрали</p> <p>Өдөр ↑ 4.17% Cap ↑ Жил ↓</p>	<p>Rio Tinto Австрали</p> <p>Өдөр ↓ 0.92% Cap ↑ Жил ↑</p>

DOW JONES	S&P 500	FTSE 100	NIKKEI 225	TOPIX	SHANGHAI COMPOSITE	HANG SENG	KOSPI
0.32%	0.037%	0.17%	0.82%	0.92%	2.50%	1.62%	0.68%